



МАНДАХ
ИХ СУРГУУЛЬ

МАНДАХ ЭРДЭМ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

ISSN:2663-256X

2024/06

ISSN: 2663-256X

МАНДАХ ЭРДЭМ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

Дугаар #11, 2024

ISSN: 2663-256X

MANDAKH RESEARCH

INTERNATIONAL SCIENTIFIC JOURNAL

2024/06

Сэтгүүлийн талаар санал, хүсэлтээ доорх хаягаар ирүүлнэ үү.

Мандах Их Сургууль,
Баянгол дүүрэг, 16-р хороо,
Амарсанаагийн гудамж 18/1, Улаанбаатар хот, Монгол,
Шуудангийн хаяг: УБ-16040, ш/х88,
7018-5950, 9918-0487

Цахим шуудан: journal@mandakh.edu.mn

Цахим хуудас: <http://journal.mandakh.org>

<http://mandakh.edu.mn>

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Эрхлэгч:	Г. Нанжид, профессор
Ерөнхий редактор:	Ч. Төрбадрах, Ph.D. профессор
Нарийн бичгийн дарга:	О.Бурмаа, Ph.D. дэд профессор
Гишүүд:	А. Наранцэцэг, Ph.D. дэд профессор Б. Цэцгээ, Sc.Ph.D. профессор Л. Энх-Амгалан, Ph.D. профессор Д. Бадарч, Ph.D. профессор С. Ганцэцэг, Ph.D. дэд профессор С. Цолмон, Ph.D. дэд профессор Г. Цагаач, Ph.D. дэд профессор Б. Оюунтунгалаг, Ph.D. дэд профессор Masaaki Aoki, Ph.D. профессор Jiang Ailin, Ph.D. профессор Andrii Kostryzhev, Ph.D. дэд профессор Wisuttorn Jitaree, Ph.D. дэд профессор Andre Eric Shimunek, Ph.D. дэд профессор

АГУУЛГА

У.Золзаяа, С.Цолмон

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА BUS1101 7

Л.Гүнжаргал, С.Цолмон

УУР УУРХАЙН ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ЧИГ ХАНДЛАГА BUS1102
.....20

Д.Оюунцэцэг, Б.Майдарбат

БАРИЛГЫН САЛБАРЫН ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ДАМПУУРЛЫН ШИНЖИЛГЭЭ
BUS110335

Ж.Гантулга, Ц.Батзаяа

STUDYING THE RELATIONSHIP BETWEEN ECONOMIC GROWTH, INFLATION, MONEY
SUPPLY AND BUDGET EXPENDITURES BUS110445

П.Баасанжаргал, Б.Нацагдорж

THE STUDY ON CURRENT SITUATION OF LEISURE ACTIVITIES IN MONGOLIA BUS1105
.....54

О.Бурмаа, М.Жанузах

КОФЕ ШОПООР ДАВТАН ҮЙЛЧЛҮҮЛЭХ ХҮСЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ХЭРЭГЛЭГЧИЙН
ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА HUM110165

Э.Ундрал

КОМПАНИЙН АШГИЙН УДИРДЛАГА БА ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦИЙН
ХООРОНДЫН ХАМААРЛЫГ ҮНЭЛЭХ НЬ HUM110277

Б.Золзаяа

ИНФЛҮҮНСЭР МАРКЕТИНГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ
HUM110390

З.Түшигмаа, Г. Энх-Отгон, А. Наранцэцэг

НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙ ЯЛГАРУУЛАЛТ НЬ ҮНДЭСНИЙ ТОДОРХОЙЛСОН ХУВЬ
НЭМРИЙН ЗОРИЛТОД ХҮРЭХ ТААМАГЛАЛ HUM110499

Ч.Төрбадрах, Ө.Мөнхзаяа

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГ
ҮНЭЛЭХ НЬ HUM1105107

О.Бурмаа, Б.Сайнжаргал, С.Цэрэнням

THE CORRELATION BETWEEN PSYCHOLOGICAL (MOTIVATION, ATTITUDE,
PERCEPTION, AND MEMORY) PROCESS AND PURCHASING INTENTION OF THE
DEPOSITORS HUM1106117

Ж.Төгсөө, Б.Энхзул, Т.Оюун-Эрдэнэ

ENHANCING VOCABULARY BASED ON BILINGUAL FLASH CARD FOR PROFESSIONAL
ENGLISH CLASSROOM HUM1107129

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

У.Золзаяа^{1a}, С.Цолмон^{2b}

¹Мандах ИС, ЭЗБТ, Багш

² Мандах ИС, ЭЗБТ, Доктор (Ph.D), профессор

[^azolzaya.u@mandakh.edu.mn](mailto:zolzaya.u@mandakh.edu.mn), [^btsolmon@mandakh.edu.mn](mailto:tsolmon@mandakh.edu.mn)

ХУРААНГУЙ

2022 оны 2-р сараас эхэлсэн ОХУ ба Украины дайнтай холбоотойгоор импортоор орж ирж буй газрын тосны үнэ сүүлийн жилүүдэд тасралтгүй өссөөр байгаа нь манай улсын инфляц болон эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Энэхүү судалгааны гол зорилго нь газрын тосны импорт, тэр дундаа хамгийн их хувийг бүрдүүлж буй автобензин болон дизелийн түлшний зах зээлийн нөхцөл байдлыг үнэлэхэд оршиж байна. Үүний тулд бид тус бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлт болон дотоодын жижиглэнгийн үнийн сар бүрийн индекс тогтоох, 2024 оны 1-ээс 12-р саруудад эдгээр бүтээгдэхүүний нийлүүлэлтийн чиг хандлага ямар байх зэрэг энэхүү зах зээлийн өнөөгийн болон ойрын чиг хандлагыг тодорхойлохыг хичээв. Судалгаандаа бид 2017 оны 1-р сараас 2023 оны 12-р сар хүртэлх тоон өгөгдлийг ҮСХ болон АМГТГ-ын статистик мэдээллийн сангаас авч ашигласан бөгөөд Holt–Winters болон Census x-13 загварууд ашиглав. Судалгааны зарим үр дүнгээс харвал ОХУ-ын дайнтай холбоотойгоор автобензин болон дизелийн түлшний дотоодын жижиглэнгийн дундаж үнэ 70 орчим хувь, нийлүүлэлтийн биет хэмжээ тус хугацаанд 30 орчим хувиар өссөн байна.

Түлхүүр үг: Тренд, мөчлөг, нийлүүлэлт, дизелийн түлш, хамаарал, сарын индекс

MONGOLIA OIL IMPORT MARKET RESEARCH

APSTRACT

Due to the war between Russia and Ukraine, which started in February 2022, the price of imported oil has been continuously increasing in recent years, which will have a negative impact on the inflation and economic growth of our country. The main goal of the main research is to improve the market conditions for oil imports, including gasoline and diesel fuel, which have the largest reserves. To this end, we tried to determine the current and near-term trends of this market, including the monthly index of supply and domestic retail prices of these products, and what the trend of supply of these products will be in January-December 2024. In our research, we used numerical data from January 2017 to December 2023 from the statistical database of the NSC and the National Statistics Office, and used the Holt–Winters and Census x-13 models. According to some research results, the average domestic retail price of gasoline and diesel fuel increased by about 70 percent, and the physical volume of supply increased by about 20 percent during the period due to the war in Russia.

Keywords: Trend, cycle, supply, diesel fuel, correlation, monthly index

ОРШИЛ

Хэдийгээр манай улс нь 250 сая орчим нефтийн нөөц байдаг ч өнөөг хүртэл түүхий нефт хэлбэрээр нь экспортолж байна. Гэвч газрын тос, тэр дундаа хамгийн өргөн хэрэглэгддэг автобензин болон дизелийн түлшээ бид ОХУ болон БНХАУ-аас 100 хувь импортолж байгаа нь дотоодын инфляциар дамжин эдийн засгийн өсөлтөд сөрөг үр нөлөөг дагуулсаар байна. Өөрөөр хэлбэл, манай улсын инфляцын өсөлтийн гол шалтгааны нэг нь шатахууны үнийн өсөлт байгаа хэдий ч бид нефт боловсруулах үйлдвэр байгуулж чадахгүй байгаагаас үүдэн эдийн засгийн алдагдсан боломж нь жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

Дизелийн түлш болон бензиний урт болон богино хугацааны эрэлтийг таамаглах чиглэлээр Ediger & Akar (2007), Sa'ad (2009), Li, Rose, & Hensher (2010), Melikoglu (2013), Barde (2014), Akpınar & Yumusak (2016), Barak & Sadegh (2016), Rehman, Cai, Fazal, Walasai, & Mirjat (2017), Ozturk & Ozturk (2018), Wang, Zhan, & Li (2019), Li & Wang (2019) гэх мэт цөөнгүй эрдэм шинжилгээний бүтээлүүд хийгдсэн байна. Эдгээр судалгаанд эрэлтийг таамаглахдаа ихэвчлэн дараах математик, статистик загваруудыг түгээмэл ашигласан байна. Үүнд:

- Autoregressive integrated moving average (ARIMA)
- Seasonal Autoregressive Integrated Moving Average (SARIMA)
- Linear and quadratic Exponential Holt Linear (HL)
- Holt-Winter Long-range energy alternate (LEAP)
- X-13ARIMA-SEATS Seasonal Adjustment
- Adaptive neuro fuzzy inference system (ANFIS)
- Modified exponential curve method (MECM)
- BP neural network model (BP)
- Bottom-up Energy Analysis System (BEAS)

Эрчим хүч, тэр дундаа дизелийн түлш болон автобензиний эрэлт, нийлүүлэлтийг таамаглаж буй судалгааны ажлуудад хамгийн түгээмэл ашиглаж буй дээрх загваруудын хувьд ARMA, ARIMA зэрэг хугацаан цуваан шинжилгээний аргуудыг Zhang (2003); Akpınar & Yumusak (2016), Suganthi and Samuel (2012), регрессийн шинжилгээний аргуудыг Sapnken, E.F., Tamba, J.G., Essiane, S.N., Koffi, F.D., Njomo, D (2018), BP, DT зэрэг хиймэл оюун ухааны аргуудыг Lai, Liu, Kuo, & Chang (2014) нар ашигласан байна. Мөн түүнчлэн Holt–Winters-ийн загварыг Kays, et al (2018), Taylor (2003), Jónsson, Pinson, Nielsen, & Madsen (2014), (Jiang, Wu, Gong, & Yu (2020) зэрэг олон судлаачид ашигласан байна.

Бидний хувьд Holt–Winters болон Census x-13 загвар ашиглах болно. Учир нь тус загвар нь гадны ижил төстэй судалгаанд хамгийн түгээмэл ашиглаж байгаагаас гадна хиймэл оюун ухаан, машин сургалт гэх мэт бусад аргуудыг ашиглахад манай улсад хангалттай хэмжээний их өгөгдөл байхгүй тул үнэлгээний үр дүн алдаатай гарах магадлал өндөр юм. Загварын нийцтэй байдлын нарийвчлалыг болон сонголт хийхдээ акиак, шварцийн шинжүүрээс гадна алдааны квадратын дундаж язгуур (RMSE), абсолют алдааны дундаж (MAE), абсолют алдааны хувийн дундаж (MAPE), тэгш хэмт абсолют алдааны хувийн дундаж (SMAPE), Theil-ийн шалгуур зэргийг ашиглах болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Холт Винтерсийн (HW-1) экспоненциаль таамаглалын арга нь улирлын нөлөөлөлгүй боловч трендтэй хугацаан цувааг таамаглана. Энэ нь \overline{X}_t , T_t 2 утгыг үнэлэх алгоритм нь энгийн экспоненциаль тэгшитгэлийн аргатай төстэй (Gelpe, Fried, & Croux, 2014).

$$\begin{aligned} 1\text{-р шат: } \overline{X}_t &= a(\overline{X}_{t-1} + T_{t-1}) + (1-a)x_t, & 0 < a < 1 \\ T_t &= bT_{t-1} + (1-b)(\overline{x}_t - \overline{x}_{t-1}), & 0 < b < 1 \\ t &= \overline{3, n} & T_2 = x_2 - x_1 & \quad \overline{x}_2 = x_2 \end{aligned}$$

а, b-тэгшитгэх коэффициентууд

2-р шат: Хамгийн сүүлийн түвшин ба трендийн үнэлгээг ашиглаж таамаглана.

$$\overline{x}_{n+h} = \overline{x}_n + hT, \quad h = 1, 2, 3, \dots$$

Холт-Винтерсийн (HW-2) арга нь улирлын нөлөөлөлтэй хугацаан цувааг таамаглах арга бөгөөд $x_3 - x_{10}$, $F_3 - F_{10}$ (1)-(3) томъёогоор тооцоолно.

$$\overline{x}_t = \frac{x_{t-\frac{s}{2}+2}(x_{t-\frac{s}{2}+1} + \dots + x_{t-\frac{s}{2}-1})x_{t+\frac{s}{2}}}{2s} \quad t = \frac{s}{2} + 1, \frac{s}{2} + 2, \dots, \frac{5s}{2} \quad (1)$$

$$T_{\frac{5s}{2}} = \overline{x}_{\frac{5s}{2}} - \overline{x}_{\frac{5s}{2}-1} \quad (2)$$

$$F_{\frac{5s}{2}-j} = \frac{1}{2} \left(\frac{x_{\frac{5s}{2}-j}}{x_{\frac{5s}{2}-j}} + \frac{x_{\frac{3s}{2}-j}}{x_{\frac{3s}{2}-j}} \right), \quad j = \overline{0, s-1} \quad (3)$$

улиралтай үед $s=4$, сартай үед $s=12$, $x_{11} - x_n$, $T_{11} - T_n$, $F_{11} - F_n$, *утгуудын үнэлгээг тооцно.*

$$\overline{x}_t = a(\overline{x}_{t-1} + T_{t-1}) + (1-a)\frac{x_t}{F_{t-s}}; \quad 0 < a < 1 \quad (4)$$

$$T_t = bT_{t-1} + (1-b)(\overline{x}_t - \overline{x}_{t-1}); \quad 0 < b < 1 \quad (5)$$


$$F_t = cF_{t-s} + (1-c)\frac{x_t}{x_t}; \quad 0 < c < 1 \quad (6) \quad t = \frac{5s}{2} + 1, n$$

Харин тухайн үнэлэгдсэн загвар нь цаашид таамаглах чадвар өндөр, алдаа багатай загвар болж чадсан эсэхийг дараах шинжүүрүүдээр шалгах бөгөөд тухайн загваруудын хувьд аль шинжүүр нь хамгийн бага байгаа нь хамгийн бага алдаатай сайн үнэлэгдсэн байна. Үүнд:

- Алдааны квадратын дундаж язгуур: $RMSE = \sqrt{\frac{\sum_{i=1}^n (y_i - \hat{y}_i)^2}{n}}$ (5)
- Абсолют алдааны дундаж: $MAE = \frac{1}{n} \sum_{i=1}^n |y_i - \hat{y}_i|$ (6)
- Абсолют алдааны хувийн дундаж: $MAPE = \frac{1}{n} \sum_{i=1}^n \left| \frac{y_i - \hat{y}_i}{y_i} \right|$ (7)
- Тэгш хэмт абсолют алдааны хувийн дундаж: $SMAPE = \frac{1}{n} \sum_{i=1}^n \frac{|y_i - \hat{y}_i|}{(|y_i| + |\hat{y}_i|)/2}$ (8)
- Theil-ийн шалгуур $U_1 = \frac{\sqrt{\frac{1}{n} \sum_{t=1}^n (y_t - f_t)^2}}{\sqrt{\frac{1}{n} \sum_{t=1}^n y_t^2 + \frac{1}{n} \sum_{t=1}^n f_t^2}}$, $U_2 = \frac{\sqrt{\frac{\sum_{t=1}^{n-1} (f_{t+1} - y_{t+1})^2}{y_t}}}{\sqrt{\frac{\sum_{t=1}^{n-1} (y_{t+1} - y_t)^2}{y_t}}}$ (9)


СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол улсад 2023 онд эрдэс бүтээгдэхүүний импорт 2,140,349.7 мян.ам долларт хүрсэн нь нийт импортын 23.1 хувийг бүрдүүлсэн байна. Газрын тосны бүтээгдэхүүний импортын биет хэмжээ 2023 онд 2,417.5 мянган тонн хүрсэн нь өмнөх оны мөн үеэсээ 28.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн газрын тосны импортын бие хэмжээний 86 орчим хувийг автобензин (30.2 хувь) болон дизелийн түлш (55.7 хувь) эзэлж байна.



Зураг 1. Гол нэрийн бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь

Харин газрын тосон бүтээгдэхүүний импорт 2024.1.1-ээс 2024.4.8-ны хооронд 722 мянган тонн импортолсноос А-80 автобензин 2.2 мянган тонн, АИ-92 автобензин 229.6 мянган тонн, АИ-95 болон АИ-98 автобензин 5.6 мянган тонн, Дизель түлш 418.2 мянган тонн Онгоцны түлш 17.9 мянган тонн, бусад түлш 37.1 мянган тонныг тус бүр импортолжээ.




Зураг 2. Гол нэрийн бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь

Жилийн дүнгээр нь үзвэл газрын тосны бүтээгдэхүүний импорт 2023 онд 2,417.5 мянган тонн хүрснээс 85.7 хувь нь автобензин болон дизелийн түлш бүрдүүлж байна. Үүнд:



Зураг 3. Газрын тосны импортод автобензин, дизелийн түлшний эзлэх хувь

Газрын тосны бүтээгдэхүүний дийлэнх хувийг бүрдүүлдэг автобензин болон дизелийн түлшний үнэ 2021 оны 6-р сараас хойш огцом өссөн байна. 2023 оны 12-р сарын байдлаар газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалтын улсын дундаж үнэ автобензин А-80 нэг литр нь 2533 төгрөг, автобензин АИ-92 2557 төгрөг, АИ-95 4031 төгрөг байгаа бол дизелийн түлш 4000 төгрөгт хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, 2021 оны 6-р сараас хойш тус бүтээгдэхүүнүүдийн жижиглэнгийн үнэ А-80 67.4 хувиар, АИ-92 65.5 хувиар, АИ-95 74.3 хувиар, дизелийн түлш 76.8 хувиар тус бүр өссөн байна. Үүнд:



Зураг 4. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэн борлуулалтын улсын дундаж үнэ

Автобензин болон дизелийн түлшний үнүүд нь хоорондоо маш өндөр (90-ээс дээш) хувийн хамааралтай байна. Үүнээс гадна автобензин А-80 болон АИ-95-ийн үнэ нь нийлүүлэлтээсээ сөрөг хамааралтай буюу нийлүүлэлт буурах үед үнэ нь өсдөг бол автобензин АИ-92 болон дизелийн түлшний үнэ нь нийлүүлэлттэйгээ эерэг (сул) хамааралтай байна. Үүнд:

Хүснэгт 1. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ болон нийлүүлэлтийн хамараал

		P80	P92	P95	PDS	Q80	Q92	Q95	QDS
Автобензин А-80 импорт	P80	100%	98%	95%	94%	-53%	48%	-23%	26%
Автобензин АИ-92 импорт	P92	98%	100%	93%	93%	-50%	48%	-21%	26%
Автобензин АИ-95 импорт	P95	95%	93%	100%	98%	-60%	48%	-32%	35%
Дизелийн түлшний импорт	PDS	94%	93%	98%	100%	-64%	47%	-34%	36%
Автобензин А-80-ийн үнэ	Q80	-53%	-50%	-60%	-64%	100%	-12%	53%	-31%
Автобензин АИ-92-ийн үнэ	Q92	48%	48%	48%	47%	-12%	100%	9%	44%
Автобензин АИ-95-ийн үнэ	Q95	-23%	-21%	-32%	-34%	53%	9%	100%	-19%
Дизелийн түлшний үнэ	QDS	26%	26%	35%	36%	-31%	44%	-19%	100%

Автобензин болон дизелийн түшний нийлүүлэлтийн сарын индексийн тооцохдоо Census х-13 (seasonal adjustment программ) загвар ашигласан бөгөөд 2014 оны 1-р сараас 2023 оны 12-р сар хүртэлх 120 сарын өгөгдлийг YCG-ийн статистик мэдээллийн сангаас авч ашиглав. Тухайлбал, автобензин А-80 нь Census х-13 загварын үнэлгээгээр 2017 оноос хойш сар бүрийн индекс нь дараах байдалтай гарсан. Үүнд:

Хүснэгт 2. Автобензин А-80-ийн нийлүүлэлтийн сар бүрийн индексийн үнэлгээ

D 10 Final seasonal factors
From 2017.Jan to 2023.Dec
Observations 84
Seasonal filter 3 x 5 moving average

	Jan Jul	Feb Aug	Mar Sep	Apr Oct	May Nov	Jun Dec	AVGE
2017	99.4 100.1	100.9 99.9	100.2 100.2	98.5 101.6	97.1 102.1	98.1 101.8	100.0
2018	99.8 100.0	101.0 100.1	100.3 100.5	98.3 101.5	96.6 102.0	98.0 101.9	100.0
2019	100.1 99.9	101.0 100.7	100.4 100.7	98.0 101.3	95.9 101.9	98.1 101.9	100.0
2020	100.4 100.0	100.8 101.2	100.3 101.1	97.9 101.1	95.3 101.6	98.4 101.8	100.0
2021	100.6 100.2	100.7 101.8	100.4 101.3	97.8 101.0	94.6 101.4	98.6 101.5	100.0
2022	100.8 100.5	100.5 102.1	100.3 101.5	97.9 100.8	94.2 101.1	99.0 101.3	100.0
2023	100.8 100.7	100.4 102.3	100.3 101.6	97.9 100.7	94.1 100.9	99.1 101.2	100.0
AVGE	100.3 100.2	100.8 101.2	100.3 101.0	98.0 101.1	95.4 101.6	98.5 101.6	
Table Total-	8399.54		Mean-	99.99	Std. Dev.-	1.83	
			Min -	94.11	Max -	102.27	

Дээрх үнэлгээг хийсний дараа Census х-13 загвараар автобензин А-80-ийн нийлүүлэлтийн сар бүрийн индекс 2024 оны 1-ээс 12-р саруудад ямар байхыг таамаглав. Үүнд:


Хүснэгт 3. Автобензин А-80-ийн нийлүүлэлтийн сар бүрийн индексийн таамаглал

D 10.A Final seasonal component forecasts
From 2024.Jan to 2024.Dec
Observations 12


	Jan Jul	Feb Aug	Mar Sep	Apr Oct	May Nov	Jun Dec	AVGE
2024	100.9 100.8	100.3 102.3	100.3 101.6	97.9 100.6	94.0 100.9	99.2 101.2	100.0

А-80 автобензинийн хувьд нийлүүлэлт нь жил бүрийн 4-өөс 5-р саруудад уналттай байдаг бол 8-аас 9-р саруудад хамгийн өндөр нийлүүлэлттэй байдаг байна. Энэ мэтчилэн Сensus х-13 загвараар АИ-92, АИ-95 болон дизелийн түлшний үнэ болон нийлүүлэлтийн (биет хэмжээгээр) сар бүрийн индексийг үнэлсэн бөгөөд үр дүнг дараах зургаар харуулав.


А-80 автобензин



АИ-92 автобензин



АИ-95 автобензин




Дизелийн түлш




Зураг 5. Газрын тосон бүтээгдэхүүний үнэ болон нийлүүлэлтийн сарын индекс

Бүх төрлийн автобензин болон дизелийн түлшний жижиглэн борлуулалтын улсын дундаж үнэ нь 1-ээс 5-р саруудад харьцангуй хямд зарагдаж байгаа бол 5-р сараас 12-р сар хүртэл өсдөг боловч тус хугацаанд дээрх бүтээгдэхүүний нийлүүлэлт сар бүр харилцан адилгүй байна. Жишээлбэл, А-80 нь 8-р сард, АИ-92 нь 11-р сард, АИ-95 нь 8, 11-р сард, дизелийн түлш нь 8 болон 1, 12-р саруудад хамгийн их нийлүүлэлт хийгддэг байна.


Автобензин А-80




Автобензин АИ-92



Автобензин АИ-95



Дизелийн түлш



Зураг 6. Газрын тосон бүтээгдэхүүний үнэ болон нийлүүлэлтийн сарын индекс

Газрын тосны бүтээгдэхүүнүүдийн нь сарын нөлөө ихтэй байгаагаас гадна цаашид АИ-92 болон дизелийн түлшний нийлүүлэлт нэмэгдэх төлөвтэй байна. Мөн эдгээр бүтээгдэхүүний трендийг шугаман, квадрат болон куб гэх мэт загваруудаар үнэлсэн бөгөөд дараах хүснэгтэд квадрат тренд бүхий загваруудын үр дүнг харуулав. Үүнд:

Хүснэгт 4. Газрын тосон бүтээгдэхүүний квадрат трендийн үнэлгээ

Үзүүлэлтүүд		А-80	АИ-92	АИ-95	Дизель
Сул гишүүн	Параметр	14151.70***	38681.05***	3750.798***	69417.99***
	t статистик	72.37478	283.6816	62.40515	49.64033
t-@TREND	Параметр	-314.2507***	-127.3643***	-57.63780***	378.8997***
	t статистик	-28.85838	-16.77250	-17.21953	4.865237
t ² -@TREND ²	Параметр	2.087410***	4.721690***	0.446125***	0.313559
	t статистик	16.44436	53.34097	11.43362	0.345392
R ²		0.972779	0.996305	0.899398	0.839378
Засварлагдсан R ²		0.972107	0.996214	0.896914	0.835412
F-статистик		1447.344	10920.92	362.0757	211.6445
Акайк шинжүүр		15.70524	14.98428	13.34593	19.63997
Шварц шинжүүр		15.79205	15.07110	13.43274	19.72679

Хүснэгт 5. АИ-92 автобензиний FE (forecast evaluation) үнэлгээний үр дүн

Forecast Evaluation

Date: 04/27/24 Time: 18:41

Sample: 2017M01 2024M12

Included observations: 96

Evaluation sample: 2017M01 2024M12

Number of forecasts: 7

Combination tests

Null hypothesis: Forecast i includes all information contained in others


Equation	F-stat	F-prob
EQ02	0.313222	0.7320
EQ05	6.655489	0.0021
EQ06	0.000000	1.0000

Evaluation statistics

Forecast	RMSE	MAE	MAPE	SMAPE	Theil U1	Theil U2
EQ02	418.8393	358.0200	0.844831	0.843913	0.004671	1.414780
EQ05	2517.453	2183.871	4.940437	4.955294	0.028096	8.059413
EQ06	289.2531	226.5252	0.488443	0.488090	0.003226	0.878277
Simple mean	899.5175	772.1421	1.727220	1.724620	0.010036	2.887777
Simple median	335.8952	267.7428	0.600535	0.599454	0.003746	1.093333
Smooth AIC weights	44835.97	44303.32	100.0000	200.0000	1.000000	145.4345
SIC weights	44835.97	44303.32	100.0000	200.0000	1.000000	145.4345


*Trimmed mean could not be calculated due to insufficient data

Газрын тосны бүтээгдэхүүн тус бүрийн загваруудаас аль загвар нь хамгийн бага алдаатай, таамаглах чадвар сайтайг нь RMSE, MAE, MAPE, SMAPE, Theil U1, Theil U1 тестээр тус бүр шалгасан. Жишээлбэл, АИ-92 автобензинийн хувьд шугаман тренд (EQ2), квадрат тренд (EQ5) болон куб (EQ6) тренд бүхий загваруудын үр дүнд FE үнэлгээг хийж үзэхэд АИ-92 автобензинийн нийлүүлэлтийг куб тренд бүхий загвараар үнэлэх нь хамгийн тохиромжтой байна. Энэ мэтчилэн бусад бүтээгдэхүүн тус бүр дээр тус үнэлгээг хийв.




Зураг 7. АИ-92 автобензиний трендийн загваруудын таамаглалын харьцуулалт


А-80 автобензин




АИ-92 автобензин



АИ-95 автобензин



Дизелийн түлш



Зураг 8. Газрын тосон голлох бүтээгдэхүүний нийлүүлэлтийн таамаглал, тонноор

Эцэст нь бид газрын тосны голлох бүтээгдэхүүний 2024 оны 1-ээс 12-р сарын импортын таамаглалыг үнэлсэн бөгөөд трендийн үнэлгээгээр гарсан таамаглалын утгуудыг Census x-13 загвараар үнэлсэн сар бүрийн индексийн нөлөөг тусган үнэлж зураг 8-д харуулав.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаараа бид газрын тосны импортын хамгийн их хувийг эзэлдэг автобензин болон дизелийн түлшний зах зээлийн нөхцөл байдал болон 2024 оны нийлүүлэлтийн чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон бөгөөд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний дотоодын зах зээл дээрх жижиглэнгийн дундаж нь ОХУ болон Украины дайнтай холбоотойгоор 2022 оны хойш 70 орчим хувиар өссөн бөгөөд ойрын хугацаанд үнэ буурах боломж харагдахгүй байна.
- Holt–Winters-ийн загвараар үнэлсэн трендийн үнэлгээнүүдээс харвал АИ-92 болон дизелийн түлшний импортын хэмжээ цаашид эрчимтэй өсөх төлөвтэй байна. Энэ нь уул уурхайн экспортын өсөлтөөс шалтгаалсан дизелийн түлшний эрэлт, суудлын авто машины өсөлтөөс үүдсэн АИ-92 автобензинийн эрэлтийн өсөлттэй холбоотой байна.
- Автобензин А-80 болон А95-ийн үнэ нь нийлүүлэлтээсээ сөрөг хамааралтай буюу нийлүүлэлт буурах үед үнэ нь өсдөг бол автобензин АИ92 болон дизелийн түлшний үнэ нь нийлүүлэлттэйгээ эерэг хамааралтай байна.
- Газрын тосны голлох бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон нийлүүлэлтэд сарын нөлөө их байгаа ба гол төлөв 4-өөс 5-р саруудад эрэлт бага байгаа бол 7-оос 8-р сар болон 11-р саруудад хамгийн их нийлүүлэлттэй байна. Тиймээс эрэлт их байдаг эдгээр саруудын газрын тосны бүтээгдэхүүний нөөцөө импортын үнэ хямд байдаг бусад саруудад авах замаар нөөц бүрдүүлэх нь эрэлтээс үүдэх үнийн өсөлтөөс сэргийлэх боломжтой юм.

ӘХ СҮРБАЛЖ

- Akpınar, M., & Yumusak, N. (2016). Year ahead demand forecast of city natural gas using seasonal time series methods. . *Energies*, , 9(9), 727.
- Barak, S., & Sadegh, S. (2016). Forecasting energy consumption using ensemble ARIMA-ANFIS hybrid algorithm. *International Journal of Electrical Power and Energy Systems*, ,82, 92-104.
- Barde, A. (2014). Modeling petroleum product demand in Nigeria using structural time series model (STSM) approach. . *International Journal of Energy Economics and Policy*, 4(3), 427-441.
- Ediger, V., & Akar, S. (2007). ARIMA forecasting of primary energy demand by fuel in Turkey. *Energy Policy*, 35(3), 1701-1708.
- Jiang, W., Wu, X., Gong, Y., & Yu, W. Z. (2020). Holt-Winters smoothing enhanced by fruit fly optimization algorithm to forecast monthly electricity consumption. . *Energy*, 193, 2-3.
- Jónsson, T., Pinson, P., Nielsen, H., & Madsen, H. (2014). Exponential smoothing approaches for prediction in real-time electricity markets. *Energies*, 7(6), 3710-3732.
- Kays, H., Karim, A., Daud, M., Varela, M., Putnik, G., & Machado, J. (2018). A collaborative multiplicative Holt-Winters forecasting approach with dynamic fuzzy-level component. *Applied Sciences (Switzerland)*, 8(4), 530.
- Lai, S., Liu, M., Kuo, K., & Chang, R. (2014). Energy consumption forecasting in Hong Kong using ARIMA and Artificial neural networks models. . *Applied Mechanics and Materials*, 672, 2085-2097.
- Li, S., & Wang, Q. (2019). India's dependence on foreign oil will exceed 90% around 2025-the forecasting results based on two hybridized NMGM-ARIMA and NMGM-BP models. *Journal of Cleaner Production*, 232, 137-153.
- Li, Z., Rose, J., & Hensher, D. (2010). Forecasting automobile petrol demand in Australia: An evaluation of empirical models. *Transportation Research Part A: Policy and Practice*, 44(1), 16-38.
- Melikoglu, M. (2013). Forecasting Turkey's natural gas demand between 2013 and 2030. *Review, Renewable and Sustainable Energy*, 22, 393-400.
- Ozturk, S., & Ozturk, F. (2018). Forecasting energy consumption of Turkey by ARIMA model. . *Journal of Asian Scientific Research*, 8(2), 52-60.
- Rehman, S., Cai, Y., Fazal, R., Walasai, G., & Mirjat, N. (2017). An integrated modeling approach for forecasting long-term energy demand in Pakistan. . *Energies*, 10(11), 1-24.
- Sa'ad, S. (2009). Transportation demand for petroleum product in Indonesia: A time series analysis. . *OPEC Review*, 33(2), 140-154.
- Sapnken, E., Tamba, J., Essiane, S., Koffi, F., & Njomo, D. (2018). Modeling and forecasting gasoline consumption in Cameroon using linear regression models. *International Journal of Energy Economics and Policy*, , 8(2), 111-120.
- Suganthi, L., & Samuel, A. (2012). Energy models for demand forecasting-a review. *Renewable and Sustainable Energy Reviews*, 16(2), 1223-1240.
- Taylor, J. (2003). Short-term electricity demand forecasting using double seasonal exponential smoothing. *Journal of the Operational Research Society*, , 54(8), 799-805.
- Wang, L., Zhan, L., & Li, R. (2019). Prediction of the energy demand trend in middle Africa-a comparison of MGM, MECM, ARIMA and BP models. . *Sustainability (Switzerland)*, 11(8), 2436.
- Zhang, G. (2003). Time series forecasting using hybrid ARIMA and neural network model. . *Neurocomputing*, 50, 485-483.

УУР УУРХАЙН ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ЧИГ ХАНДЛАГА

Л.Гүнжаргал^{1a}, С.Цолмон^{2b}

¹Мандах ИС, ЭЗБТ, Доктор (Ph.D)

² Мандах ИС, ЭЗБТ, Доктор (Ph.D), профессор

^agunjargal.l@mandakh.edu.mn, ^btsolmon@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Уул уурхайн ашигт малтмалын нөөц нь аж үйлдвэрийн салбарын голлох түүхий эд бөгөөд Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбар гэгдэх уул уурхайн салбар нь экспортын 92 хувийг дангаараа бүрдүүлж байгаа бөгөөд 2023 оноос МХБ-ээр дамжуулан нүүрс, төмрийн хүдрийн экспортыг биржээр экспортлох болсон нь тус салбарын хөгжилд төдийгүй манай улсын эдийн засагт ихээхэн эерэг нөлөө үзүүлж эхлээд байна. Энэхүү судалгаагаараа бид Монгол улсын уул уурхайн экспорт, тэр дундаа МБХ-ээр арилжаалагдах төмрийн хүдэр, зэс, жонш, нүүрсний арилжаа болон экспортын хэмжээний урт хугацааны төлөв байдлыг тодорхойлохыг зорив. Судалгааны зарим үр дүнгээс дурдвал ойрын ижлүүдэд БНХАУ-ын эдийн засаг, тэр дундаа аж үйлдвэрийн салбар нь өсөх төлөвтэй байгаа нь нүүрс, зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлдэг Монгол, ОХУ, Австрали, БНАСУ зэрэг орнуудын эдийн засагт эерэг нөлөөлөхөөр байна. Мөн түүнчлэн 2030 он гэхэд МХБ-ээр арилжаалах уул уурхайн экспортын хэмжээ 24.2-оос 36.6 сая ам.долларт хүлэх төлөвтэй байна.

Түлхүүр үг: Баяжмал, таамаг нөөц, зэсийн хүдэр, дундаж үнэ, олборлолт

EXPORT TRENDS OF MAIN MINING PRODUCTS

APSTRACT

Mining mineral resources are the main raw materials of the industrial sector, and the mining sector, which is called the leading sector of Mongolia's economy, alone accounts for 92 percent of exports. Starting from 2023, the export of coal and iron ore through the stock exchange of Mongolia has started to have a significant positive impact not only on the development of the sector, but also on the economy of our country. In this study, we aim to determine the long-term trend of Mongolia's mining exports, including trade and export volumes of iron ore, copper, fluorspar, and coal traded on the Mongolian Stock Exchange. Some of the research results show that China's economy, especially its industrial sector, is expected to grow in the near future, which will have a positive impact on the economy of Mongolia, Russia, Australia, and the Republic of Korea, which supply mining products such as coal and copper. Also, by 2030, the amount of mining exports traded on the Mongolian stock exchange is expected to reach 24.2 to 36.6 million US dollars.

Keywords: Concentrate, estimated reserves, copper ore, average price, production

ОРШИЛ

Уул уурхайн салбар нь дэлхийн эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдлыг бий болгоход гол хувь нэмэр оруулдаг байгалийн нөөц (Amirshena & Osanloo, 2019) бөгөөд улс орнуудад тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тус салбарын үүрэг, оролцоо нэн чухал байна (Nansai, et al., 2019). Тухайлбал, БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын гол түүхий эд болох уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь тус улсын эдийн засгийн өсөлтөд томоохон нөлөө үзүүлсээр жирээ (Lei, Cui, & Pan, 2013). Нөөцийн хараат байдлын онол (Pfeffer & Salancik, 2003) болон харилцан хамаарлын онол (Allen, 2018) ёсоор улс орнууд худалдааны нягт харилцаатай байхын тулд харилцан үр ашигтай байх зарчимд тулгуурладаг.

Монгол улсын хувьд УИХ-аас 2022.12.23-ны өдөр “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль” баталж, 2023.07.01-ий өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн нь экспортоор гаргаж буй уул уурхайн бүтээгдэхүүний үнийг нээлттэй, шударга байдлаар буюу зах зээлийн зарчмаар ил тод экспортлох боломж бүрдүүлсэн байна (УИХ, 2022). Тус биржийн үйл ажиллагааны экосистем нь СЗХ, МХБ, УУХҮЯ зэрэг төрийн байгууллага; нүүрс, зэс, төмрийн хүдэр, жонш гэсэн уул уурхайн бүтээгдэхүүнээс гадна уул уурхай, тээвэр, брокер болон гадаад дотоодын худалдан авагч компаниудаас бүрдэж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд цар тахал, дайн, өндөр инфляц, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг төрөл бүрийн хүндэл учирсаар байгаа нь улс орнуудын эдийн засагт ихээхэн сөрөг нөлөө үзүүлсээр байна. ОУВС-гийн 2023 оны 12-р сард гаргасан “Дэлхийн эдийн засгийн төлөв байдал”-ын тайланд дурдсанаар, дэлхийн эдийн засгийн өсөлт 2022 онд 3.5%, 2023 онд 3% болж буурсан бол 2024 онд 2.9% болж буурах төлөвтэй байгаа нь 2000-2019 оны түүхэн дунджаас 3.8%-иар доогуур хэвээр байна. Азийн хөгжингүй орнуудын өсөлт 2023 онд 5.2% байгаа бол 2024 онд 4.8% болж буурах төлөвтэй байна (Hassen, 2023).

Азийн орнуудын эдийн засаг нь 2030 он хүртэл өсөх төлөвтэй байгаа ба 2020 онд тус бүс нутгийн эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн 48.3 хувийг бүрдүүлдэг байсан бол 2030 онд 53.6 хувийг бүрдүүлэхээр байна. Эдийн засгийн хэмжээгээр дэлхийд хоёрт бичигдэж буй БНХАУ-ын хувьд 2024 онд 4.2%-ийн өсөлттэй байх ба 2030 онд дэлхийн хамгийн том эдийн засагтай улс болж АНУ-ыг ардаа үлдээх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, 2030 онд БНХАУ-ын ДНБ нь 43.9 их наяд доллар, АНУ улс 28.7 их наяд, Энэтхэг улс 17.9 их наяд долларт тус бүр хүрэх төлөвтэй байна.

Ойрын жилүүдэд Азийн орнууд, тэр дундаа БНХАУ-ын эдийн засаг өсөх төлөвтэй байгаа нь манай улсын уул уурхайн экспорт болон эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Учир нь уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нь манай улсын эдийн засгийн өсөлт болон экспортын голлох хувийг бүрдүүлж байгаа ба цаашид томоохон ордуудын ашиглалт болон эрэлт хэрэгцээ, боомтуудын сэргэлт, төмөр замын хөгжил зэргээс шалтгаалаад тус салбар нь ойрын хугацаанд илүү өндөр өсөлт үзүүлэхээр байна.


УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

а. Уул уурхайн салбарын олон улсын улсын нөхцөл байдал

Дэлхий дахинаа цахимжсан эдийн засагт шилжиж буй энэ үед уул уурхай салбарт ихээхэн боломжууд гарч ирсээр байна. Эрдэс баялгийн эрэлт, хэрэгцээ цаашид улам бүр нэмэгдэх төлөвтэй байгаа нь хүм амын өсөлт, аж үйлдвэржилт, дижитал шилжилт, геополитик болон эдийн засгийн хурдацтай өсөлт зэрэг нь ийнхүү эрэлт нэмэгдэхэд хүргэж байна гэж Олон улсын эрчим хүчний агентлагаас мэдээлсэн байна (IEA, 2021).


Дэлхий дээрх ашигт малтмалын олборлолт болон үйлдвэрлэл нь цөөн тооны үйлдвэрлэгч оронд төвлөрсөн ба эрчим хүчний шилжилтэд шаардлагатай олон ашигт малтмалын үйлдвэрлэл газрын тос, шатдаг хийтэй харьцуулбал илүү их төвлөрсөн байна. Лити, кобальт, газрын ховор элементийн хувьд дэлхийн топ гурван үйлдвэрлэгч орон дэлхийн үйлдвэрлэлийн дөрөвний гурвыг хянаж байна. Конго Улс болон БНХАУ нь кобальт, газрын ховор элементийн дэлхийн үйлдвэрлэлийн 70 болон 60 орчим хувийг тус тус гаргаж байв.

Боловсруулалтын түвшний хувьд төвлөрөл их байдаг бөгөөд Хятад энэ талаар хүчтэй байр суурь эзэлдэг. Баяжуулалт дахь Хятадын эзлэх хувь никелийн 35%, лити болон кобальтын 50-70%, газрын ховор элементийн бараг 90% байна. Хятадын компаниуд бас Австрали, Чили, БНКУ, Индонези дэх гадаадын капитал хөрөнгөд томоохон хөрөнгө оруулсан. Төвлөрлийн өндөр түвшин ханган нийлүүлэлтийн нарийн төвөгтэй байдалтай хавсраад гол үйлдвэрлэгч орнууд дахь биет тасалдал, худалдааны хязгаарлалт, бусад сөрөг хүчин зүйл үүсэн гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна (Reichl & Schatz, 2023).



Зураг 1. Дэлхийн уул уурхайн нийт үйлдвэрлэл, бүсээр

Өдгөө дэлхий дахинд зарим эрдэс, түүхий эдийн эрэлт, хэрэгцээ нь нийлүүлэлтээсээ хэд дахин илүү болоод байгаа нь цаашид зарим ховор металл, эрдэс түүхий эдийн үнэ болон эрэлтийг улам бүр нэмэгдүүлэх төлөвтэй байна.



Зураг 2. Ашигт малтмал үйлдвэрлэлээр тэргүүлэгч онрууд, дүнд эзлэх хувиар
Эх сурвалж: IEA (2021a). The Role of Critical Minerals in the Energy Transition

2023-2032 оны хооронд уул уурхайн салбарын CAGR 4.2% байх төлөвтэй байгаа ба ашигт малтмалын нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнүүд хүний биед зайлшгүй шаардлагатай эрдэс бодисоор хангадаг хүнсний нэмэлт бүтээгдэхүүн юм. 2022 онд ашигт малтмалын нэмэгдэл бүтээгдэхүүний дэлхийн зах зээл 13.3 тэрбум орчим Ашигт малтмалын бэлдмэлийг шахмал, капсул, нунтаг гэх мэт олон хэлбэрээр авах боломжтой. Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн асуудал, зөв хооллолтын талаарх мэдлэг нэмэгдсэнтэй холбоотойгоор дэлхийн эрдэс нэмэлтүүдийн зах зээл хурдацтай хөгжиж байна.

Цахилгаан машины ашиглаж дууссан батарейны тоо хэмжээ 2030 оноос хойш огцом өсөх хүлээлттэй байгаа бөгөөд тэр үед ашигт малтмалын эрэлт хурдан өссөн хэвээр байх болно. 2040 он гэхэд ашиглаж дууссан батарейгаас дахин боловсруулан гаргаж авсан зэс, лити, никель, кобальтын тоо хэмжээ эдгээр ашигт малтмалын анхан шатны нийлүүлэлтийн нийлбэр хэрэгцээг 10%-иар бууруулах болов уу гэсэн тооцоо бий. Дахин боловсруулахын ашиг тус нь цэвэр эрчим хүчний технологи илүү ихээр суурилуулсан бүс нутагт илүүтэй байж болох бөгөөд тэр нь томрох тусам ашигтай ажиллах зарчмаас үүдэлтэй байх юм.

Хаягдал болсон тоног төхөөрөмжөөс амин түүхий эдийг авч дахин боловсруулах нь янз бүрийн бүтээгдэхүүний химийн бүтэц, тархац өргөн хүрээний байдаг учраас нарийн төвөгтэй бөгөөд олоогийн байдлаар бүх тоног төхөөрөмж дахин боловсруулалтад орох зориулалтгүй, эд ангийн байршил хол, овор хэмжээ том (ялангуяа турбины сэнс) байдгаас логистикийн сорилт тулгардаг байна. Дийлэнх металлыг шинж чанарыг алдагдуулалгүй дахин боловсруулж болдог учир хангалттай тоо хэмжээ, дахин боловсруулах байгууламж байгаа нөхцөлд дахин боловсруулах нь металлын томоохон эх үүсвэр болж чадна.

б. Монгол улсын уул уурхайн салбарын өнөөгийн байдал

ОУВС-аас манай улсыг хөгжиж буй, байгалийн баялаг хамгийн ихтэй 29 орнуудын нэг гэж тодорхойлсон бөгөөд гол төлөв нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр нь голлох экспортын голлох бүтээгдэхүүн болж байна. 2010-2023 онд уул уурхайн олборлолт 16.09 хувь байсан ба 2023 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо 2776, нийт талбайн хэмжээ 6,903.2 мянган га байгаагаас ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо 1721, хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 1005 ширхэг байна. Үүнд:

Хүснэгт 1. Ашигт малтмалын хүчин төлөгдөл тусгай зөвшөөрлийн тоо /2023.12-сар/

Бүгд			Үүнээс:					
			Ашиглалт		Хайгуул		Хайгуул	
Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь
2726	6,903.2	4.4%	1721	1,836.7	1.2%	1005	5,066.5	3.2%

Эх сурвалж. ЗГХА, Ашигт малтмал газрын тосны газар

Ашиглалтын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын нэр төрлөөр нь авч үзвэл давхардсан тоогоор нийт 108 нэр төрлийн ашиглалтын ашигт малтмалын зөвшөөрөл байгаа. Тэдний 57 орчим хувь нь алт (459 тусгай зөвшөөрөл буюу 26.7 хувь), нүүрс (304 тусгай зөвшөөрөл буюу 17.7 хувь), жонш (216 тусгай зөвшөөрөл буюу 12.6 хувь) бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 2. Ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын төрлөөр

№	Бүгд	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Талбайн хэмжээ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Алт /Шороо/	459	26.70%	185,540.9	10.10%
2	Нүүрс	304	17.70%	786,732.3	42.80%
3	Жонш	216	12.60%	57,843.2	3.10%
4	Алт /Үндсэн/	96	5.60%	131,043.2	7.10%
5	Төмөр	81	4.70%	52,444.2	2.90%
6	Шохойн чулуу	81	4.70%	50,885.8	2.80%
7	Түгээмэл, Элс, Хайрга	33	1.90%	1,283.9	0.10%
8	Түгээмэл, Шавар	33	1.90%	2,032.2	0.10%
9	Түгээмэл, Дайрга	32	1.90%	9,071.3	0.50%
10	Гянтболд	29	1.70%	9,062.1	0.50%
11	Бусад	26	1.50%	8,761.2	30.00%

Эх сурвалж. ЗГХА, Ашигт малтмал газрын тосны газар

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын тоо 2023 онд 1750 байгаагаас дотоодын ААНБ-ын эзлэх хувь 76.2 байна. 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай 253 байгаагаас 142 буюу 56.2 хувь нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай байгууллагууд байна. Мөн түүнчлэн 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага 26 улсаас байгаагаас дараах 6 улсаас хамгийн их компани тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Манай улсад энэхүү салбарыг хөгжүүлэх чиглэлээр тогтвортой хөгжлийн зорилт; төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын үзэл баримтлал; Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр зэрэг хөгжлийн баримт бичиг цөөнгүй байна. “Алсын хараа-2050”-

ийн зорилтыг хангах “Шинэ сэргэлтийн бодлого”-д Боомтын сэргэлтийн тэргүүлэх чиглэлд багтааж, экспортыг нэмэгдүүлэх бодлого баримталж эхлээд байна. Одоогоор 80 төрлийн ашигт малтмалын 1170 орчим орд 8000 гаруй илрэл бүртгэгдсэн байна. Үүнд:

Төмрийн ордын нөөц: Геологичид Монголд нэг тэрбум тонн төмрийн хүдрийн нөөцтэй гэсэн таамаг дэвшүүлдэг. Монголын геологичид төмрийн хүдрийн ордын 14 гол бүс нутаг тогтоон судалгаа хийж, 11 тэрбум тонн төмрийн хүдрийн таамаг нөөц; тогтоогдсон нөөц нь 1.2 тэрбум тонн гэж тодорхойлсон байна. АНУ-ын Геологийн албаны мэдээлснээр дэлхийн төмрийн хүдрийн нөөц 180 тэрбум тонн бөгөөд дараах 12 улс нийт төмрийн хүдрийн нөөцийн 95.7 хувийг бүрдүүлж байна. Дэлхий дээр Австрали, Бразил, ОХУ-ууд нь хамгийн их нөөцтэй байгаа ба Монгол улсын хувьд тогтоогдсон нөөцөөрөө 12-р байранд эрэмбэлэгдэж байна. Хэрэв 11 тэрбум таамаг нөөцөө баталгаажуулбал дэлхийд нүүрсний нөөцөөрөө 4-р байранд орох боломжтой байна.

Зэсийн ордын нөөц: 2023 оны байдлаар дэлхийн зэсийн батлагдсан нөөцийг 870 сая тн гэж тооцоолоод байгаа. Харин зэсийн ордууд дахь боломжит нөөц нь 2.1 тэрбум тн байгаа бол илрээгүй ордуудын нөөцийг 3.5 тэрбум тн гэж тооцоолсон байна. Харин Монгол улсын хувьд зэсийн нөөц 61.4 сая.тн буюу дэлхийд батлагдсан нөөцийн хэмжээгээрээ эхний 5-д багтаж байгаа ба 2.1 тэрбум таамаг нөөц батлагдвал эхний 3-т эрэмбэлэгдэхээр байна.

Нүүрсний ордын нөөц: Нийт 15 сав газарт 300 гаруй орд байгаа ба нөөцөөрөө дэлхийд 8-д багтдаг. 12 нүүрсний сав газар, 3 нүүрстэй талбайд нүүрсний нийт батлагдсан геологийн нөөц 32.6 тэрбум.тн байгаа ба шинжлэх ухааны доктор Д.Бат-Эрдэнэ Геологичайгуулын нэмэлт судалгаагаар илрүүлэх боломжтой нөөц баялаг 150 тэрбум.тн байна гэсэн байна. Өөрөөр хэлбэл, таамаг нөөцөө баталгаажуулж чадвар дэлхийд эхний 2-р байранд орох боломжтой байна. Одоогоор дэлхийн нийт тогтоогдсон нүүрсний нөөц 894,552 тэрбум тонн бол АНУ нүүрсний нөөцийн 27.83 хувийг дангаараа бүрдүүлдэг байна.

Жоншны нөөц: Монгол улс жоншны 163 орд, 545 илэрцтэй бөгөөд 90% нь Дорноговь, Төв, Хэнтий, Дундговь, Сүхбаатар аймгуудад төвлөрдөг. Жоншны нөөц, үйлдвэрлэлийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг улсын нэг нь Монгол улс бөгөөд “US Geological Survey. Mineral commodity summaries 2018” судалгааны мэдээллээр 32 сая тонн минералын нөөц буюу 100 сая тонн хүдрийн нөөцтэй гэж бүртгэгджээ. Монгол улс энэ үзүүлэлтээрээ Хятад, Мексик, Өмнөд Африкийн дараа дэлхийд 4-р байранд эрэмбэлэгдэж байна. Өөрөөр хэлбэл, Дэлхийн хайлуур жоншны нийт нөөц 500 сая орчим тонн бол Монгол улс нийт нөөцийн 9%-ийг эзэлж байгаагаас гадна жонш чанараараа дэлхийд тэргүүлдэг байна¹.

¹ http://www.touristinfocenter.mn/news_more.aspx?CateID=0&NewsID=4421

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Монгол улсын нэрлэсэн ДНБ 2023 онд 68,87 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлсэн үнээр тооцсон бодит ДНБ нь 30.45 их наяд төгрөг гарсан бөгөөд эдийн засгийн өсөлт 7 орчим хувьтай гарсан. Үүний голлох хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн бөгөөд 2023 онд уул уурхайн салбарын нэрлэсэн ДНБ-ний хэмжээ өмнөх оноос 23.4 хувиар өссөн байна.



Зураг 3. Монгол улсын нэрлэсэн ДНБ болон эдийн засгийн өсөлт, улирлаар


“Алсын хараа 2050” хөгжлийн бодлогод 2030 онд ДНБ-ны хэмжээ 47.6 тэрбум ам.доллар, инфляц 6 хувь, нэг хүнд ногдох ДНБ 12,054 ам.доллар байхаар төсөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, 2030 онд бодит ДНБ-ны хэмжээ 52.5 их наяд төгрөг буюу 2023 оноос 1.72 дахин их байгаа тул зорилтот түвшиндээ хүрэхийн тулд жилд дунджаар 6 хувиар өсөх шаардлагатай байна (УИХ, 2020). Монгол улсын эдийн засгийн өсөлтийг ОУВС-аас 2028 он хүртэл жилд дунджаар 4 хувиар өснө гэж төсөөлсөн (O'Neill, 2023) бол Дэлхийн банк 2024 оноос эхлэн жилд дунджаар 6-аас дээш хувиар өснө гэж таамаглаж байна (IBRD-IDA, 2023). Үүнд:

Хүснэгт 3. Макро эдийн засгийн зарим үзүүлэлтийн таамаглал, Дэлхийн банк

	2023	2024	2025	2026
Real GDP growth, at constant market prices	5.8	6.2	6.4	6.1
Private consumption	5.7	11.3	4.5	6.3
Government consumption	13.6	11.3	1.8	3.4
Gross fixed capital formation	7.0	15.4	1.7	7.5
Exports, goods and services	42.3	3.6	20.3	6.3
Imports, goods and services	16.8	18.4	15.4	9.2
Real GDP growth, at constant factor prices	5.8	6.2	6.4	6.1
Agriculture	-10.7	11.5	5.0	6.5
Industry (including mining)	13.6	5.0	11.3	9.4
Servises	6.9	5.4	4.0	4.0

Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засгийн хамгийн том салбаруудын нэг бөгөөд 2023 оны байдлаар нэрлэсэн ДНБ-ний 23 орчим хувийг дангаараа бүржүүлж байна. Цаашид ч салбарын эзлэх хувь өсөх байгаа ба “Алсын хараа 2050”-д 2030 он гэхэд ДНБ-


ний 31.4 хувийг уул уурхайн экспорт бүрдүүлнэ гэж төсөөлсөн байна. Бидний хийсэн тооцоогоор 2030 онд ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь 29 орчим хувтай байхаар байна. Үүнд:



Зураг 4. Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь, 2030 онд

Монгол улсад өнөөгийн байдлаар нүүрс, зэс, төмрийн хүдэр, түүхий нефт зэрэг 10 орчим уул уурхайн эрдэс, бүтээгдэхүүн экспортолж байгаагаас нийт уул уурхайн экспортын 87.5 хувийг чулуун хүүр болон зэсийн баяжмалын экспортууд дангаараа бүрдүүлж байна. 2023 онд Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 24,437.0 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3,194.0 сая ам.доллар буюу 15.0 хувиар өссөн байна.


Уул уурхайн экспортыг бүтцээр нь задалж үзвэл чулуун хүүрс 61.6 хувь, зэсийн баяжмал 25.9 хувь, төмрийн хүдэр 3.7 хувь, файлын хүдэр, баяжмал 2.7 хувь, түүхий нефт 2.3 хувь, жоншны хүдэр 1 хуувийг бүрдүүлж байна.



Зураг 5. Бомтуудаар хийгдсэн экспортын хэмжээ, дүнд эзлэх хувиар

Нийт экспорт 2023 оны гүйцэтгэлээр 15,184.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2,645.9 сая ам.доллар буюу 21.1 хувиар өссөн байна. Эрдэс бүтээгдэхүүний экспорт 13,989.2 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 2,233.6 сая ам.доллар буюу 19.0 хувиар өссөн байна. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, баяжмал, цайрын

баяжмал, хайлуур жоншны хүдэр, баяжмал, молибдены баяжмал, газрын тос, алт, мөнгө, катодын зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 92.1 хувийг эзэлж байна.




Зураг 6. Эрдэс бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллар

Үнэлгээг шугаман, квадрат зэрэг олон аргуудаар үнэлсэн бөгөөд статистик ач холбогдол өндөртэй дээрх загварт тулгуурлан тус салбарын экспортыг дараах байдлаар таамаглав.

Уул уурхайн нийт экспорт, сая ам.доллар	2024	2025	2026	2027	2028	2029	2030
	13,023	14,806	16,785	18,970	21,372	24,004	26,874


Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээрх уул уурхайн зарим түүний эдийн үнэ эрчимтэй өссөөр байна. Тэр дундаа аль, зэс зэрэг металлуудын үнэ нь цаашид улам их өсөх төлөвтэй байгаа нь эдгээр металлуудыг үйлдвэрлэдэг улсуудад ихээхэн боломж олгож байна.



Зураг 7. Жонш болон зэсийн үнийн таамаглал, 2024-өөс 2030 он.

2023 оны жилийн эсийн байдлаар нэг тонн жонш ойролцоогоор 355 ам.доллар байгаа бол 2030 онд 372 ам.доллар болох төлөвтэй байна. Харин зэсийн үнэ 2030 онд 1 тонн нь 11,790 ам.доллар болох төсөөлөлтэй байгааг дээрх зургаас харж болно. Мөн түүнчлэн 2023 онд төмрийн хүдэр дунджаар 104 ам.доллар, нүүрс 114 ам.доллар байгаа бол 2030 онд эдгээр уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ нь тус бүр 140 болон 135 ам.доллар байгаар байна. Өөрөөр хэлбэл, урт хугацаанд нэг тонн нүүрсний үнэнд

өөрчлөлт орохгүй, харин төрийн хүдрийн үнэ ирэх 7 жилийн хугацаанд 18.3 орчим хувиар өсөхөөр байна.



Зураг 8. Төмрийн хүдэр болон нүүрсний үнийн таамаглал, 2024-өөс 2030 он.


Энэхүү тооцоолол нь 2015-аас 2023 оны ханшийн мэдээнд тулгуурлан эконометриксийн шугаман регрессийн арга ашиглан тооцоолсон болно. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн жилүүдийн ханшийн тренд ирэх жилүүдэд хадгалагдана гэсэн нөхцөлөөр загвараа боловсруулав.

2023 онд МХБ-ээр дамжуулан 299 удаагийн уул уурхайн экспортын арилжаа хийгдэж 15.6 сая тонн арилжигдсан ба нүүрс 14.9 сая тонн, төмрийн хүдэр 677.4 мянган тонн тус тус арилжигджээ. Өөрөөр хэлбэл, арилжааны 96 хувийг нүүрсний арилжаа бүрдүүлсэн байна. Нүүрсний арилжааны үнийн дүн 7.3 их наяд төгрөг байгаагаас 4.9 их наяд нь дэгдэмхий бодис дунд коксжих нүүрс, 1.07 их наяд нь 1/3 коксжих нүүрсний арилжаа, 949.9 тэрбум төгрөг нь баяжуулсан коксжих нүүрс, 238 тэрбум нь эрчим хүчний нүүрс, 0.93.15 тэрбум төгрөг нь баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа тус бүр хийгдсэн байна. Үүнд:

Хүснэгт 4. 2023 онд арилжигдсан нүүрсний хэмжээ.


№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ /тонн/	Үнийн дүн /төгрөг/	Хувь
1	Баяжуулсан коксжих нүүрс	1,472,000	949,969,925,760	12.9%
2	Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс	9,036,800	4,939,918,375,770	67.3%
3	Баяжуулсан сул коксжих нүүрс	140,800	68,146,995,200	0.9%
4	1/3 коксжих нүүрс	2,937,600	1,074,880,606,950	14.6%
5	Баяжуулсан хагас хатуу коксжих нүүрс	153,600	36,572,042,240	0.5%
6	Эрчим хүчний нүүрс	1,075,200	238,561,609,338	3.2%
7	Дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрс	108,800	35,793,374,771	0.5%
8	Чийг багатай хүрэн нүүрс	12,800	1,350,018,560	0.0%
Нийт		14,937,600	7,345,192,948,589	100%

2023 онд уул уурхайн нийт экспортын хэмжээ 13,551.8 сая ам.долларт хүрснээс 19.4 хувь нь зэсийн хүдэр, баяжмал; 64.7 хувь нь нүүрс; 3.3 хувь нь төмрийн хүдэр; 2.0 хувийг жонш бүрдүүлж байгаа ба эндээр нь нийт уул уурхайн экспортын 89.3 хувийг бүрдүүлж байна. 2015 оноос хойш нийт экспортод нүүрсний эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа бол зэсийн эзлэх хувийн жин буурсаар байна. Гэвч зэсийн ордуудын олборлолт болон эрэлт хэрэгцээ цаашид өсөх төлөвтэй байгаа тул энэхүү хувь хэмжээ өөрчлөгдөх боломжтой байна.




Зураг 9. Биржээр арилжаалагдах бүтээгдэхүүний нийт уул уурхайн экспортод эзлэх хувь

Дээрх 4 нэр төрлийн бүтээгдэхүүний нийт уул уурхайн экспортод эзлэх хувь цаашид жил бүр өсөхөөр байгаа ба 2030 онд нийт экспортын 95.8 орчим хувийг бүрдүүлэхээр байна.



Зураг 10. Биржээр арилжаалагдах бүтээгдэхүүний нийт уул уурхайн экспортод эзлэх хувь

2024 онд биржээр арилжаалагдах 4 төрлийн бүтээгдэхүүн нь уул уурхайн экспортын 86.9 хувь буюу 11,317.9 сая ам.долларын экспорт хийхээр байгаа бол 2030 онд уул уурхайн экспортод эзлэх хувь нь 95.8 буюу эдгээр 25,743.0 сая ам.долларт хүрэхээр байна. Үүнд:



Зураг 11. Нийт болон биржээр арилжаалагдах уул уурхайн экспортын хэмжээ, сая ам.доллар

Биржээр арилжаалагдах зэсийн хүрийн эзлэх хувийн жин 2024 онд 28.7 хувь байх бол 2030 онд 20.2 хувь болж буурах төлөвтэй байна. Харин нүүрсний эзлэх хувийн жин 63.3 хувиас 71.5 хувь болж өсөх төлөвтэй байна. Үүнд:

Хүснэгт 5. Биржээр арилжаалагдах бүтээгдэхүүний экспортын таамаглал, сая ам.доллар

Бүтээгдэхүүн		2024	2025	2026	2027	2028	2029	2030
Зэсийн хүдэр	Хувь	28.7%	27.3%	25.8%	24.4%	23.0%	21.6%	20.2%
	Дүн	3,742.7	4,036.7	4,332.6	4,625.9	4,911.9	5,185.5	5,441.1
Жоншны хүдэр	Хувь	1.4%	1.3%	1.1%	0.9%	0.8%	0.6%	0.4%
	Дүн	186.8	186.9	183.6	176.0	163.5	145.1	120.1
Төмрийн хүдэр	Хувь	6.5%	6.7%	7.0%	7.2%	7.4%	7.6%	7.8%
	Дүн	848.6	998.7	1,169.7	1,363.8	1,582.8	1,828.8	2,103.8
Нүүрс	Хувь	63.3%	64.7%	66.1%	67.5%	68.8%	70.2%	71.5%
	Дүн	8,244.4	9,584.1	11,099.3	12,804.4	14,714.3	16,844.1	19,209.4
Нийт дүн		13,022.6	14,806.4	16,785.2	18,970.1	21,372.5	24,003.5	26,874.5

Монгол улсын Засгийн газраас ойрын жилүүдэд “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Боомтын сэргэлт” зэрэг хөгжлийн бодлогуудын хүрээнд уул уурхайн экспортыг нэмэгдүүлэхээс гадна биржээр арилжаалагдах экспортын хэмжээг нэмэгдүүлэх талаар чиглэл гарган ажиллаж байна. Тухайлбал, 2024 онд дээрх уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 20-оос 30 хувийг, 2026 онд 80-аас 90 хувийг, 2029 оноос хойш 90-ээс 95 хувь болон түүнээс дээш хувийг МБХ-ээр дамжуулах экспортолж байхаар төлөвлөж байна. Биржээр арилжаалагдах уул уурхайн экспортын хэмжээг өөдрөг, дундаж, гутранги гэсэн 3 хувилбараар тооцоолсон бөгөөд цаашид дундаж гэсэн хувилбарыг сонгон үнэлгээ хийв.

Хүснэгт 6. МБХ-ээр арилжаалагдах уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллар

Хувилбар		2024	2025	2026	2027	2028	2029	2030
Өөдрөг төсөөлөл	Хувь	30.0%	60.0%	90.0%	92.5%	93.8%	95.0%	95.0%
	Дүн	3,906.8	8,883.8	15,106.7	17,547.3	20,036.7	22,803.3	25,530.8
Дундаж төсөөлөл	Хувь	25.0%	55.0%	85.0%	88.8%	90.6%	92.5%	92.5%
	Дүн	3,255.7	8,143.5	14,267.4	16,836.0	19,368.8	22,203.2	24,858.9
Гутранги төсөөлөл	Хувь	20.0%	50.0%	80.0%	85.0%	87.5%	90.0%	90.0%
	Дүн	2,604.5	7,403.2	13,428.2	16,124.6	18,700.9	21,603.2	24,187.1

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаараа бид уул уурхайн салбарын экспорт, тэр дундаа хөрөнгийн биржээр арилжаалагдах төмрийн хүдэр, зэс, жонш, нүүрсний арилжаа болон экспортын хэмжээний урт хугацааны төлөв байдлыг тодорхойлохыг зорьсон бөгөөд дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

- Ойрын ижлүүдэд БНХАУ-ын эдийн засаг, тэр дундаа аж үйлдвэрийн салбар нь өсөх төлөвтэй байгаа нь нүүрс, зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлдэг Монгол, ОХУ, Австрали, БНСАУ зэрэг орнуудын эдийн засагт эерэг нөлөөлөхөөр байна.
- Монгол улсын эдийн засгийн өсөлт ойрын жилүүдэд 5-аас 6 хувиар өсөх төлөвтэй байгаа нь уул уурхайн салбарын өсөлтөөс шалтгаалсан ба 2023 онд эдийн засгийн өсөлт 7 хувь байсан бол уул уурхайн салбарын нэрлэсэн ДНБ 23.4 хувиар өсжээ.
- Монгол оронд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд 8000 гаруй илрэл бүртгэгдсэн бөгөөд нүүрсний тогтоогдсон нөөц 32.6 тэрбум тонн, зэс 870 сая тонн, жонш 100 сая тонн, төмөр 1.2 тэрбум тонн байгаа ч таамаг нөөцүүд тогтоогдвол дээрх уул уурхайн бүтээгдэхүүний нөөцөөр дэлхийд тус бүр эхний 10-д орох боломжтой юм.
- “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг хангах зорилго бүхий шинэ сэргэлтийн бодлогын нэг чиглэл болох “Боомтын сэргэлт”-ийн бодлого нь тус салбарын экспортын хэмжээнд ихээхэн эерэг нөлөө үзүүлэхээр байна.
- Уул уурхайн салбар нь 2023 онд байдлаар нэрлэсэн ДНБ-ний 23 хувийг бүржүүлж байна. Харин “Алсын хараа 2050”-д 2030 он гэхэд ДНБ-ний 31.4 хувийг уул уурхайн салбар бүрдүүлнэ гэж төсөөлсөн бол бидний судалгаагаар энэхүү салбарын ДНБ-д эзлэх хувь 2030 он гэхэд 29 орчим хувь буюу 26.8 тэрбум ам.доллар байхаар байна.
Discretionary accruals, an indicator of earnings management, were calculated using Modified Jones Model. The relationship between earnings management and ownership structure was examined using 2018-2022 financial report data of 80 companies listed on the Mongolian Stock Exchange. We performed regression analysis using earnings management as the dependent variable, ownership concentration, manager's ownership, foreign ownership, institutional ownership and state ownership as independent variables; financial performance, financial leverage and company size as control variables. Results show that foreign ownership has a negative relationship with earnings management and financial performance has a positive relationship with earnings management. Other independent variables have no significant relationship with earnings management.

Keywords: discretionary accruals, ownership structure, Modified Jones model, Mongolia

ОРШИЛ

Ашиг нь компанийн гүйцэтгэлийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд ашгийн удирдлага нь дэлхий даяар анхаарууштай асуудал болсон байна. Компани санхүүгийн тайлангаа өөрт ашигтай байдлаар харуулахын тулд санаатайгаар санхүүгийн тайлангийн өөрчлөлтүүдийг хийх үед ашгийн удирдлага үүсдэг. Компани зорилгот ашигтаа хүрэх, хувьцааны үнэд нөлөөлөх, хөрөнгө оруулагчдад илүү таатай байдлаар харагдах зэрэг тодорхой зорилгод хүрэхийн тулд ашгийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Ашгийн удирдлага нь компанийн гүйцэтгэх удирдлага болон хөрөнгө оруулагчдын хооронд мэдээллийн тэнцвэртэй бус байдлыг үүсгэдэг буюу оролцогч талууд компанийн санхүүгийн гүйцэтгэлийн талаар бодит мэдээллээр хангагдах боломжгүй болдог. Ингэснээр санхүүжүүлэгчид болон оролцогч бусад этгээдүүдийн санхүүгийн шийдвэр буруу гарах, шударга өрсөлдөөний зарчмыг зөрчих, хөрөнгө оруулалт буурах зэргээр нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавартай юм.

Монгол улсад аж ахуйн нэгж байгууллагуудын тоо маш эрчимтэй өсөж байна. 2018 онд нийт 161 мянган ААНБ бүртгэлтэй байсан бол 2023 онд энэ тоо 229 мянга болж өссөн байна. Үүнээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 95 мянган компани байна. Эдгээр компани үнэн зөв санхүүгийн мэдээлэл хүргэж буй эсэх нь улс орны эдийн засагт шууд болон шууд бусаар ихээхэн нөлөөллийг үзүүлэх тул санхүүгийн тайлангийн чанар нь чухал ач холбогдолтой юм. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц нь ашгийн удирдлага хийх боломжийг хязгаарлахад ашигладаг хяналтын механизмуудын хэрэгжилтэд чухал нөлөөтэй байдаг. Цаашлаад төр ашгийн удирдлага хувьцаа эзэмшигчдийн бүтцээс хамаарч байгаа эсэхийг үнэлэхгүйгээр аливаа зохицуулалт хийх нь үр дүнгүй тул эдгээрийн хамаарлыг үнэлж, ашгийн удирдлагыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлого, арга замыг судлан тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

Судалгааны үндэслэл

- Ашгийн удирдлага нь компанийн хувьцааны үнийг удирдах хүслээс үүдэлтэй байдаг. Үүний талаар өмчлөл болон удирдлага нь тусдаа, компанийн засаглал сайн, хөрөнгийн зах зээл хөгжсөн орнуудад голчлон судалсан байна. Монгол улсын хөрөнгийн зах зээл хөгжиж буй, хөрөнгө оруулагчдын хамгаалалт, компанийн засаглал сул байна.
- Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд нь хувьцааны төвлөрөл өндөртэй байна. Зарим салбаруудад төрийн оролцоо өндөр ба гадаадын хөрөнгө оруулалт сүүлийн үед эрчимтэй нэмэгдэж байна.
- Монгол улсад хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон ашгийн удирдлагын хоорондын хамаарлыг судалсан судалгаа ховор байна.

Судалгааны ажлын зорилго

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын ашгийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хоорондын хамаарлыг судлах.

Судалгааны ажлын зорилтууд

- Ашгийн удирдлагын онол, арга зүйг судлах

- Хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-уудын санхүүгийн мэдээлэлд шинжилгээ хийн, ашгийн удирдлагын хэмжээг үнэлэх
- Ашгийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хоорондын хамаарлыг үнэлэх

Судалгааны арга зүй

Ашгийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хоорондын хамаарлыг үнэлэхийн тулд судалгааны ажилдаа олон хүчин зүйлийн регрессийн аргыг ашигласан ба Microsoft excel программ, SPSS, Stata програмуудыг ашиглана. Мөн санал дүгнэлт гаргахын тулд харьцуулах, нэгтгэн дүгнэх арга аргачлалуудыг ашигласан болно.

Судалгааны ач холбогдол

Монгол компаниудын санхүүгийн тайлагналын чанартай холбоотой хийгдсэн судалгаа харьцангуй цөөн байна. Тиймээс энэхүү судалгаа нь нээлттэй хувьцаат компаниудын санхүүгийн тайлагналын чанар тэдгээрийн өмчийн бүтэцтэй хамааралтай эсэхийг тодорхойлж буйгаараа ач холбогдолтой юм. Энэхүү судалгааны ажлаараа Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын төрийн, гадаадын, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын болон гүйцэтгэх удирдлагын өмчлөл нь ашгийн удирдлагад нөлөө үзүүлж байгаа эсэхийг судалсан болно.

СУДЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА

Ашгийн удирдлагатай холбоотой олон улсад 2018 оноос хойш хийгдсэн судалгаануудын мэдээллийг SCOPUS дата сангаас авч библиометрийн анализ хийхэд ашгийн удирдлагын судалгаанд хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй түлхүүр үгс нь бодит ашгийн удирдлага, компанийн засаглал, санхүүгийн тайлагналын чанар, санхүүгийн гүйцэтгэл, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, агентын онол зэрэг байна.

Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанартай холбоотой судалгаа Монгол улсын хувьд маш цөөн байгаа боловч олон улсад энэ чиглэлийн судалгаа олон судлаачдын анхаарлыг татаж, нэлээдгүй судалгаа хийгдсэн байна. Хийгдсэн судалгаануудын нийтлэг үр дүн нь гадаад болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчид компанийн томоохон хувьцаа эзэмшигч байх нь ашгийн удирдлагад сөргөөр нөлөөлдөг гэх дүгнэлт байна, мөн хувьцааны төвлөрөл болон төрийн оролцоо нь ашгийн удирдлага хэрэгжүүлэхэд түлхэц болж өгдөг гэж үзсэн боловч сүүлийн жилүүдэд хийгдсэн зарим судалгаа энэхүү дүгнэлтийн эсрэг баримтыг харуулж эхэлснээр, хувьцааны төвлөрөл нь ашгийн удирдлагад хэрхэн нөлөөлдөг нь судлаачдын дунд мэтгэлцээний сэдэв болсон байна.

Ашиг нь компанийн гүйцэтгэлийг гол хэмжүүрүүдийн нэг юм. Ашгийн удирдлага нь компаниуд санхүүгийн мэдээлэл тайлагналдаа өргөн хэрэглэдэг арга хэрэгсэл юм (Guo & Ma, 2015). Судлаач Nguyen, Le, Vu (2021) нар компанийн удирдлага тайлагнаж буй ашгаа нэмэх эсвэл бууруулах үйл ажиллагааг ашгийн удирдлага гэж тодорхойлсон байна. Компаниуд шинжээчдийн таамаглал, гэрээний зорилтот түвшинд хүрэх эсвэл зах зээлд сөрөг мэдээлэл тарааж болохуйц ашгийн хандлагаас зайлсхийх зорилгоор ашгийг удирддаг байна. Ашгийн удирдлага нь хөрөнгө оруулагчдыг буруу шийдвэр гаргах эрсдэлд оруулахаас гадна компанийн бодит гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй юм. Ашгийн

удирдлага илрэх нь санхүүгийн тайлан дах мэдээллийн чанар болон найдвартай байдлыг бууруулдаг гэж үзсэн байна.

Компанийн өмчийн бүтэц нь хяналтын түвшинтэй шууд хамааралтай ба үр ашигтай өмчийн бүтэц нь ашгийн удирдлагыг хязгаарладаг (Nguyen, Le, Vu, 2021). Португал улсын засаглалын бүтэц нь байгууллагын томоохон хөрөнгө оруулагчид удирдлагын шийдвэр гаргалтад шууд болон шууд бусаар чухал нөлөө үзүүлэх эрх мэдэлтэй буйгаар тодорхойлогдсон байна.

Судлаач Г.Гантулга (2018) санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарт нөлөөлөгч хүчин зүйлсийг судлан “Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарын удирдлагын хүрд”-ийг боловсруулсан байна. Мөн Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын 2012-2016 оны санхүүгийн тайлангийн чанарыг Сайжруулсан Жонсын загварыг ашиглан үнэлэхэд 33.1% нь чанартай тайлантай байсан бол үлдсэн 66.9%-д хэвийн бус аккруэл буюу ашгийн зохицуулалт илэрсэн байна. Энэ нь засаглалын зарчимд нийцээгүй үйл ажиллагаа ба удирдлагын ёс зүйн дутагдалтай байдлаас хамаарч буй үр дүн гарсан байна.

Судлаач С.Цэвээнжаргал (2021) Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 53 хувьцаат компанийн ашгийн удирдлагыг Сайжруулсан Жонсын загвараар тооцоолсон ба нэгдүгээр ангиллын компаниуд ашгийн удирдлагагүй, хоёр болон гуравдугаар ангилалд бүртгэлтэй компаниудад ашгийн удирдлага байна гэсэн үр дүнд хүрсэн.

АШГИЙН УДИРДЛАГА

Ашгийн удирдлага гэдэг нь компанийн удирдлага хувийн ашиг сонирхол болон компанийн зах зээлийн үнэ цэнийг хамгийн дээд хэмжээнд байлгах зорилгоор санхүүгийн тайлагналын үйл явцад чиглэсэн гаднын буюу хөндлөнгийн оролцоо юм. Компани гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хүрэх, санхүүгийн хүндрэлээс зайлсхийх, татварыг бууруулах, хувьцааны үнэд нөлөөлөх зорилготой ашгийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Ашгийн удирдлага нь тайлагнасан ашгийг өсгөх (бууруулах) менежерийн үйлдэл юм. Энэ нь үр дагавар болон хүсэл эрмэлзэл гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсгээр тайлбарлагддаг (Fischer & Rosenzweig, 1995). Ашгийн удирдлага илрэх нь санхүүгийн тайлан дах мэдээллийн чанар болон найдвартай байдлыг бууруулна.

Ашгийн удирдлага нь менежер болон хөрөнгө оруулагчдын хоорондох мэдээллийн тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг ба хөрөнгө оруулагчдын хувьд сул талыг үүсгэдэг байна (Nguyen, Le, & Vu, 2021). Ашгийн удирдлага нь санхүүгийн гүйцэтгэлийг гажуудуулснаар хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлж, зах зээлийн итгэлийг алдуулж санхүүгийн тайлан хэрэглэгчдэд сөрөг үр дагаврыг авчирч болно. Ашгийн удирдлагад компанийн хүчин зүйлс (компанийн хэмжээ, салбар, санхүүгийн байдал), удирдлагын шинж чанар (удирдлагын нас, хувь эзэмшил), компанийн засаглал (ТУЗ-ын бүрэлдэхүүн, аудиторын хараат бус байдал), зохицуулалтын орчин (нягтлан бодох бүртгэлийн стандарт, хуулийн хэрэгжилт) зэрэг нөлөөлдөг байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны таамаглал

Судлаач Shleifer & Vishny (1986) нар нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрсдийн хөрөнгө оруулалтаа хамгаалахын тулд компанийн хяналтын системийг дэмжих болон нөлөөлдөг талаар дурдсан байна. Судлаач Dechow, Sloan & Sweeney (1996) нар томоохон хувьцаа эзэмшигчид компанийн гүйцэтгэх удирдлагыг хянадаг учраас тэдгээр нь ашгийн удирдлагыг хэрэгжүүлэх боломж нь багасдаг гэж үзсэн байна. Хөрөнгийн биржид бүртгэлтэй ихэнх компани өмч хувьчлалаар бүртгэгдсэн ба хувьцаа нь цөөн тооны хувьцаа эзэмшигчдэд төвлөрсөн байдаг. Тиймээс компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь ихэвчлэн хяналтын багц эзэмшигч байдаг.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчид шинжилгээ хийх, ашгийн удирдлагыг илрүүлэх мэдлэг чадвартай байдаг. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид урт хугацаанаас илүүтэйгээр богино хугацааны ашигт илүү анхаардаг талаар өмнөх судалгаануудад илэрсэн байна. Монгол дахь мэргэжлийн хөрөнгө оруулагчид буюу банк, санхүү, даатгал, хөрөнгө оруулалтын компаниуд нь туршлагатай мэргэжилтэн болон хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл сайтай байдаг.

Агентын онолын дагуу менежерийн хувь эзэмшил өндөр байх нь компанийн үнэ цэнийг өсгөх түлхэц болдог. Менежер компанийн хувьцааг эзэмших үед түүний сонирхол хувьцаа эзэмшигчдийн сонирхолтой нийцэж эхэлдэг (Jensen & Meckling, 1976). Судлаач Sandra Alves (2012) менежерийн хувь эзэмшил өндөр байх нь ашгийн удирдлагыг бууруулдаг гэж үзсэн байна. Эсрэгээрээ, менежер компанийн хувьцааг эзэмших нь аливаа хариуцлага хүлээх айдасгүйгээр өөрийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх боломжийг олгодог (Morck, 1988). Монголын компаниудын хувьд эзэн нь өөрөө менежер нь байх тохиолдол их байдаг. Иймд компанийн эзэн болон менежерийн зорилго, сонирхол нэгдсэн байж болно.

Төрийн өмчит компаниудад засаглал болон аудитын чанар сул байдаг (Shleifer, 1998) тул менежерийн эрх мэдэл өндөр байдаг. Энэ нь ашгийн удирдлагыг хэрэгжүүлэх сэдэл болох боломжтой байна. Үүнээс гадна төрийн компаниудын менежер нь олон нийт, иргэдийн янз бүрийн эрх ашиг, сонирхлыг бодолцох шаардлагатай болдог (Bruton et al., 2015) нь мөн мэдээллийн тайлагналд хөндлөнгөөс оролцох, ашгийн удирдлагыг бий болгох магадлалтай байдаг.

Гадаад хөрөнгө оруулагчид ихэвчлэн хамтын сан эсвэл бусад мэргэжлийн хөрөнгө оруулагчид байдаг (Dahlquist & Robertson, 2001). Гадаад хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын хувьцаа эзэмшигчдээс илүү компанийн менежментийг хянах хүсэлтэй байж болно. Түүнчлэн хөгжиж буй орнуудын хувьд гадаад хувьцаа эзэмшигчид илүү үр дүнтэй хяналтын аргуудыг эзэмшиж болно (Khanna and Paleru, 2000). Тиймээс дараах таамаглалуудыг дэвшүүлж байна.

H1: Хувьцааны төвлөрөл ба ашгийн удирдлага хооронд эерэг хамаарал байна.

H2: Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил ба ашгийн удирдлага хооронд эерэг хамаарал байна.

H3: Менежерийн эзэмшил ба ашгийн удирдлага хооронд сөрөг хамаарал байна.

H4: Төрийн эзэмшил ба ашгийн удирдлага хооронд эерэг хамаарал байна.

H5: Гадаад хувьцаа эзэмшигчдийн эзэмшил ба ашгийн удирдлага хооронд сөрөг хамаарал байна.

Ашгийн удирдлагад хувьцаа эзэмшигчдийн бүтцээс гадна компанийн бусад шинж чанарууд нөлөөлдөг. Тиймээс судалгаанд ашигласан хяналтын хувьсагчдыг тайлбарлая.

Компанийн хэмжээ

Томоохон компаниуд ихэвчлэн дотоод удирдлагын сайн тогтолцоотой, хатуу дотоод хяналттай байдаг ба Big 4 зэрэг томоохон, нэр хүндтэй аудитын компаниудаар хянагддаг учраас ашгийн удирдлагыг хэрэгжүүлэх магадлал бага байдаг гэж зарим судлаачид үзсэн байна (Warfield et al., 1995).


Санхүүгийн гүйцэтгэл

Компанийн санхүүгийн гүйцэтгэлийн нэг хэмжүүр нь хөрөнгийн өгөөж юм. Судлаач Lee, Li, Yue (2006) нар компанийн ашигт ажиллагаа сайн байх үед хувьцааны үнийг унагахгүйн тулд ашгийн удирдлага хэрэгжүүлдэг гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Үүнээс гадна ашиг багатай, алдагдалтай компаниуд ашгаа удирдах илүү магадлалтай талаар судлаач Chen et al. (2006) дурдсан байна.

Санхүүгийн хөшүүрэг

Санхүүгийн хөшүүрэг болон ашгийн удирдлагын хооронд эерэг хамаарал байгаа талаар олон судалгаанд дурдсан байна. Санхүүгийн хөшүүрэг өндөртэй компаниуд өр, хөрөнгийн харьцаа, хүрэх ёстой орлого, ашгийн түвшин зэргийг багтаасан гэрээ байгуулдаг. Өрийн харьцаа өндөр байх тусам компаниуд зээлийн гэрээний шаардлагуудыг биелүүлэхийн тулд ашгийн удирдлагыг хэрэгжүүлдэг байна (Efendi et al., 2007). Эсрэгээрээ өрийн зохистой харьцааг хадгалах нь компанийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ гэсэн үзэл бодол байдаг. Өртэй компаниудад зээлдүүлэгчдийн тавих хяналт нэмэгдэх учир менежерүүдэд ашгийг удирдах боломж хязгаарлагдмал болно (Chung et al., 2005).

Судалгааны арга зүй



Зураг 1 Судалгааны загвар

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Ашгийн удирдлага болон хувьцаа эзэмшигчийн бүтцийн хоорондын хамаарлыг судлахын тулд дараах регрессийн загварыг ашигласан. Хамааран хувьсагчаар ашгийн удирдлагыг, үл хамааран хувьсагчаар хувьцааны төвлөрөл, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил, менежерийн эзэмшил, төрийн эзэмшил, гадаад хөрөнгө

оруулагчдын эзэмшил, хяналтын хувьсагчаар санхүүгийн хөшүүрэг, санхүүгийн гүйцэтгэл болон компанийн хэмжээг тус тус авч үзсэн.

$$DACC_{i,t} = \beta_0 + \beta_1(OWN) + \beta_2(MAN) + \beta_3(INS) + \beta_4(GOV) + \beta_5(FOR) + \beta_6(SIZE) + \beta_7(LEV) + \beta_8(ROA)$$

Энд:

- DACC : Хэвийн бус аккруэл
- OWN : Хувьцааны төвлөрөл
- INS : Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил
- MAN : Менежерийн эзэмшил
- GOV : Төрийн эзэмшил
- FOR : Гадаад хувьцаа эзэмшигчдийн эзэмшил
- SIZE : Нийт хөрөнгийн натурал логарифм
- LEV : Нийт өр төлбөр / Нийт хөрөнгө
- ROA : Хөрөнгийн өгөөж, Цэвэр ашиг / Нийт хөрөнгө

Ашгийн удирдлагыг шууд ажиглах замаар илрүүлэх боломжгүй байдаг тул хэвийн бус аккруэлд суурилан тооцоолох аргыг ашигладаг байна. Аккруэл гэдэг нь компанийн мөнгөн гүйлгээ, авлага, өглөг, бараа материалын өөрчлөлтөд нөлөөлөх тайлант хугацааны үйл ажиллагаа юм. Судлаач Jones (1991) ашгийн удирдлагыг хэрэгжиж буй эсэхийг тодорхойлохын тулд нийт аккруэлийг хэвийн болон хэвийн бус аккруэлд хуваасан. Хэвийн бус аккруэл нь ашгийн удирдлага буюу санхүүгийн тайлангийн мэдээлэлд удирдлагын үзүүлсэн нөлөөг харуулна (Г.Гантулга, 2018). Хэвийн бус аккруэлийг тооцоолох аргууд дундаас хамгийн түгээмэл ашиглагддаг нь Жонсын загвар ба сайжруулсан Жонсын загвар юм. Сайжруулсан Жонсын загвар нь орлогын үзүүлэлтийг оруулснаараа илүү сайн гэж тооцогддог. Chen et al. (2015); Gaio & Pinto (2018); Katmon & Faroouque (2017); Wang & Yung (2011) зэрэг олон судлаачдын ажил дээр үндэслэн энэхүү судалгаандаа Dechow et al. (1995) ба Bartov et al. (2001) нарын боловсруулсан Сайжруулсан Жонсын загварыг ашиглав.

Хүснэгт 1 Хувьсагчдын тайлбар

Хувьсагч	Хувьсагчийн тайлбар
DACC	Хэвийн бус аккруэл
OWN	Хувьцааны төвлөрөл, 5%-иас их
INS	Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хувьцааны хэмжээ
MAN	Менежерийн эзэмшил, менежерийн эзэмшиж буй хувьцааны хэмжээ
GOV	Төрийн эзэмшил, төрийн эзэмшиж буй хувьцааны хэмжээ
FOR	Гадаад хувьцаа эзэмшигчдийн эзэмшил, гадны хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хувьцааны хэмжээ
SIZE	Компанийн хэмжээ, нийт хөрөнгийн натурал логарифм
LEV	Хөшүүрэг, нийт өр төлбөр / нийт хөрөнгийн эхний үлдэгдэл
ROA	Хөрөнгийн өгөөж, цэвэр ашиг / нийт хөрөнгө

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Өгөгдөл цуглуулах болон шинжилгээ хийх арга

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд дээр судалгаагаа хийсэн. 2023 оны 3-р сарын 31-ний байдлаар хөрөнгийн биржид нийт 182 компани бүртгэлтэй байна. Хамрах хугацаанд санхүүгийн мэдээлэл дутуу 77 компанийг судалгаанд оруулаагүй болно. Мөн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд буюу

банк, даатгал, брокер, үнэт цаасны компаниудыг бүртгэлийн аргачлал, стандарт нь бизнесийн компаниудаас өөр учир түүврээс хассан. Ийнхүү 2018-2022 оны хоорондох санхүүгийн мэдээлэл бүрэн 80 компанийн санхүүгийн мэдээлэлд шинжилгээ хийсэн. Судалгааны өгөгдлийг хөрөнгийн биржийн вэбсайт дах нээлттэй компаниудын мэдээлэл ба ebalance сайт дах компаниудын санхүүгийн тайлангаас цуглуулсан.

Хүснэгт 2 Түүврийн шалгуур

Ангилал	I	II	III	Нийт
МХБ-д нийт бүртгэлтэй компани	23	45	114	182
Хасах нь: Санхүүгийн байгууллага	13	4	8	25
Тасралтгүй мэдээлэлгүй	1	8	68	77
Судалгааны түүвэр	9	33	38	80

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Excel, SPSS програмуудыг ашиглан статистик шинжилгээг хийсэн бөгөөд хувьцаат компаниудын ашгийн удирдлагыг Сайжруулсан Жонсын загвараар тооцоолж, өмчийн бүтэц хоорондын хамаарлыг үнэлсэн.

ЭМПИРИК СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан компаниудын санхүүгийн тайланд тулгуурлан загварт шаардагдах хувьсагчуудын тодорхойлогч статистикуудыг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 3 Судалгаанд хамрагдсан хувьсагчуудын тодорхойлогч үзүүлэлтүүд

Хувьсагч	N	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж утга	Стандарт хазайлт
DACC	400	-822	1.020	.0027	.158
OWN	400	34.950	100.000	86.710	11.335
MAN	400	.000	99.840	37.533	35.049
INS	400	.000	44.790	3.583	9.341
FOR	400	.000	99.660	3.729	13.856
GOV	400	.000	100.000	13.46	32.024
ROA	400	-1.964	0.627	.011	.135
LEV	400	.000	4.221	.441	.480
SIZE	400	10.291	20.780	16.050	2.007

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Энд: DACC = хэвийн бус аккруэл, OWN = хувьцааны төвлөрөл, MAN = менежерийн эзэмшил, INS = мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил, GOV = төрийн эзэмшил, FOR = гадаад хувьцаа эзэмшигчдийн эзэмшил, LEV = нийт өр төлбөр / нийт хөрөнгө, ROA = хөрөнгийн өгөөж, SIZE = нийт хөрөнгийн натурал логирифм

Судалгаанд хамрагдсан компаниудын хөрөнгийн өгөөжийн (ROA) дундаж нь 0.011 байгаа нь судалгаанд хамрагдсан компаниуд ашигтай ажиллаж буйг харуулж байна. Судалгаанд хамрагдсан 80 компанийн хувьцааны төвлөрөл (OWN) дунджаар 86.71 хувь байна. Өмчийн бүтэц дундаас менежерийн эзэмшил (MAN) хамгийн өндөр (37.53%), мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил (INS) хамгийн бага (3.58%) байна.

Хэвийн бус аккруэлийн (DACC) дундаж хэмжээ 0.0027 байгаа нь компаниуд ашгийн удирдлагыг хэрэгжүүлж буйг илтгэнэ. Хэвийн бус аккруэлийн дундаж утга нь Европын орнуудад 0.00489, Латин Америкийн орнуудад 0.00656 гэсэн судалгаа байдаг (Г.Гантулга, 2018). Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хэвийн бус аккруэлийн дундаж утга Европын орнуудын дунджаас 1.8 дахин бага байна. Бүртгэлтэй

компаниудын нийт хөрөнгийн дундаж хэмжээ 13.6 тэрбум төгрөг, санхүүгийн хөшүүрэг (LEV) 44.1%, хөрөнгийн өгөөж (ROA) дунджаар 1.1% байна.

Хүснэгт 4 Хэвийн бус аккруэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн хамаарал

	DACC	OWN	MAN	FOR	INS	GOV	ROA	LEV	SIZE
DACC	1.000								
OWN	-.032	1.000							
MAN	.109	.062	1.000						
FOR	-.182	.107	-.201	1.000					
INS	.001	-.100	-.173	-.021	1.000				
GOV	-.045	.382	-.434	-.113	-.098	1.000			
ROA	.321	-.013	.034	-.087	-.070	.003	1.000		
LEV	-.153	-.019	-.113	.555	-.103	-.139	-.161	1.000	
SIZE	.003	.248	-.343	.180	-.099	.450	.220	.061	1.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 4-өөс харахад хувьсагчуудын хоорондох корреляцийн коэффициент 0.6-аас бага байгаа нь мультиколлинярын асуудал байхгүйг илтгэж байна (Hair, Black, Babin, & Anderson, 2006).

Панел өгөгдлийн хэмжээнээс хамаарч тогтмол нөлөөллийн загвар болон санамсаргүй нөлөөллийн загварын алийг ашиглахаа шийдвэрлэдэг. Тогтмол нөлөөллийн загварын үр дүнг хүснэгт 5-т харуулж байна. Энэхүү загвараар хугацааны нөлөө ба компаниудын онцлог нь хэвийн бус аккруэлийг өөрчлөхөд нөлөөлдөг байж магадгүй юм.

Хүснэгт 5 Тогтмол ба санамсаргүй нөлөөллийн загвар, Хаусманы тестийн үр дүн

Variable	FEM		REM	
	Coefficient	p-value	Coefficient	p-value
OWN	0.0063	0.566	0.00001	0.983
MAN	0.0012	0.979	0.0002	0.39
INS	-0.0058	0.627	0.0004	0.698
FOR	-0.0188	0.903	-0.0015	0.058
GOV	0.0000		-0.0002	0.605
ROA	0.3578	0.000	0.3612	0.000
LEV	0.0192	0.807	-0.0081	0.712
SIZE	0.0355	0.285	0.0004	0.944
_cons	-1.0786	0.439	-0.0082	0.937
Adjusted R-squared	0.0494		0.1341	
F-statistics	5.24		55.59	
Hausman test				
Chi-Sq. Statistic			3.86	
Prob.			0.796	

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тогтмол нөлөөллийн загварын үр дүн санхүүгийн гүйцэтгэлээс бусад хувьсагч хэвийн бус аккруэлд нөлөө үзүүлэхгүй гэсэн үр дүн гарсан байна. Санамсаргүй нөлөөллийн загварын үр дүнд санхүүгийн гүйцэтгэлээс бусад тайлбарлагч хувьсагчдын р-утга 5 хувиас их байгаа нь мөн хэвийн бус аккруэлд нөлөөгүйг харуулж байна.

Хаусманы тестийн магадлалын утга нь 5 хувиас их байгаа учир санамсаргүй нөлөөний загварыг ашиглах нь тохиромжтой гэсэн үр дүн гарч байна. Статистикийн хувьд ач холбогдолгүй хэдий ч бид үнэлгээний үлдэгдэл санамсаргүй хэмжигдэхүүний утгуудыг ашиглан зарим тайлбар хийх шаардлагатай юм. Тиймээс Хаусманы тестээр

дээрх хоёр загварын аль нь илүү тохиромжтой болохыг шалгасан болно. Судалгаанд ашигласан эконометрик загварын үнэлгээний тэгшитгэлийн үлдэгдэл (алдаа) нь хэвийн бус бөгөөд энэ нь тэгээс ялгаатай байх нь уг компанийн санхүүгийн тайлангийн чанар эргэлзээтэй буюу ашгийн зохицуулалт байгаа гэж үзнэ.

Хүснэгт 6 Регрессийн үр дүн

DACC	Коэффициент	Стандарт хазайлт	t	P > t	95% conf. interval	
OWN	-.0000	.0007	-.03	.978	-.0015	.0015
MAN	.0002	.0003	.94	.348	-.0003	.0008
INS	.0003	.0008	.46	.643	-.0013	.0021
GOV	-.0001	.0003	-.56	.574	-.0008	.0004
FOR	-.0015	.0007	-2.18	.030	-.0028	-.0002
ROA	.3578	.0586	6.11	.000	.2428	.4730
LEV	-.0089	.0192	-.46	.644	-.0466	.0288
SIZE	.0000	.0046	.00	.997	-.0089	.0089
_cons	.0014	.0914	.02	.988	-.1783	.1811
F test	7.57	Adjusted R-squared		.116		
Prob > F	.000	Number of observations		400		
R-squared	.131					

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дээрх хүснэгтээс харахад детерминацийн коэффициент буюу $R^2=0.131$ байгаа нь бие даасан хувьсагчид (хувьцаа эзэмшигчдийн бүтэц) нь хамааралтай хувьсагчийн (ашгийн удирдлага) нийт өөрчлөлтийн 13.1%-ийг тайлбарлаж чадахыг харуулж байна. Энэхүү үр дүн нь Ashiq & Tabasam (2022), Setiawan, et al (2020) ба Kotanidis & Papadopoulos (2017) судлаачдын $R^2=17\%$, 14.06% , 16.04% гэсэн үр дүнгүүдтэй ойролцоо байна.

Үр дүнгээс харахад гадаадын эзэмшил (FOR) нь ашгийн удирдлагатай 5%-ийн ач холбогдлын түвшинд (-2.18 , $p=0.03$) сөрөг бага (-0.0015) хамааралтай байгаа нь Таамаглал 5-г баталж байна. Энэхүү үр дүн нь Khanna & Palepu (2000) ба Ferreira & Matos (2008) нарын судалгааны үр дүнтэй нийцэж байна. Тэд гадаадын хөрөнгө оруулагчид илүү мэдлэгтэй, хяналтын эрх мэдэлтэй байдаг тул ашгийн удирдлагыг хязгаарладаг талаар дурдсан байна. Түүнчлэн, санхүүгийн гүйцэтгэл (ROA) нь 1%-ийн ач холбогдлын түвшинд (6.11 , $p=0.0001$) ашгийн удирдлагатай эерэг (0.35) хамааралтай байна.

Хувьцааны төвлөрөл (OWN) нь ашгийн удирдлагатай сөрөг (-0.00002) боловч ач холбогдолгүй (-0.03 , $p=0.978$) хамааралтай. Менежерийн эзэмшил (0.94 , $p=0.348$), мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил (0.46 , $p=0.643$) болон төрийн эзэмшил (-0.56 , $p=0.574$) нь ашгийн удирдлагатай статистикийн ач холбогдолгүй буюу хамааралгүй байна. Өөрөөр хэлбэл хэвийн бус аккруэлд эдгээр хувьсагчид нөлөө үзүүлэхгүй байгаа буюу хэвийн бус аккруэлыг таамаглахад эдгээр хувьсагчид ач холбогдолгүй байна гэсэн үг юм. Энэхүү үр дүн нь Таамаглал 1-4-г няцааж байна. Дээрх үр дүн нь судлаач Ashiq & Tabasam (2022) нарын Пакистаны компаниуд дээр хийсэн судалгааны үр дүн буюу компанийн хэмжээ, санхүүгийн хөшүүрэг ба мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшил ашгийн удирдлагад нөлөөлдөггүй гэсэн үр дүнтэй нийцэж байна. Мөн энэхүү судалгааны үр дүн нь Wati & Gultom (2021) нарын Индонезийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд дээр хийсэн судалгааны үр дүнтэй таарч байна.

ДУГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар өндөр байснаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талууд бодитой, зөв шийдвэр гаргах боломжтой болно. Мэдээллийн чанар нь компанийн гадаад болон дотоод олон хүчин зүйлээс шууд болон шууд бус хамааралтай байдаг. Энэхүү судалгааны зорилго нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын ашгийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хоорондын хамаарлыг судлах юм. Ашгийн удирдлагын сэдэв нь олон улсад хангалттай судлагдсан сэдэв боловч Монгол улсын хувьд шинээр судлагдаж буй сэдэв юм. Тиймээс ашгийн удирдлагыг хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй хамааралтай эсэхийг судалж байгаагаараа энэхүү ажил нь ач холбогдолтой юм.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй 80 компанийн 2018 – 2022 оны санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийсэн. Ашгийн удирдлагыг тооцоолох загваруудаас сайжруулсан Жонсын загварыг ашиглан хэвийн бус аккруэлыг хэмжсэн.

Шинжилгээний үр дүнд Таамаглал 1-4 няцаагдсан буюу ашгийн удирдлага болон хувьцааны төвлөрөл, менежерийн эзэмшил, төрийн эзэмшил, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хооронд ач холбогдол бүхий хамаарал илрээгүй. Харин компани гадаад хөрөнгө оруулагчдын эзэмшилтэй байх нь хэвийн бус аккруэл буюу ашгийн удирдлагад нөлөөлдөг буюу сөрөг хамааралтай гарсан нь Таамаглал 5-ыг дэмжсэн. Мөн компанийн санхүүгийн гүйцэтгэл нь ашгийн удирдлагатай эерэг хамааралтай гэсэн үр дүн гарсан.

Судалгааны үр дүнд хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон ашгийн удирдлагын хоорондын хамаарал илрээгүй нь манай улсад компанийн бүтэц жинхэнэ утгаараа ялгарч хөгжөөгүй, хэлбэр төдий байж болох талтайгаас гадна ашгийн удирдлагын өөрчлөлтөд нөлөөлөх бусад олон хүчин зүйл байдагтай холбоотой гэж үзэж байна. Мөн олон компанийн мэдээлэл ашигласан нь эргээд тайлангийн чанар муу, хуурамч тайлан бэлтгэдэг компаниуд судалгаанд орсонтой холбоотой энэхүү үр дүн гарсан байж болно.

Судлаачийн зүгээс онолын болон эмпирик судалгаанд үндэслэн санхүүгийн тайлангийн чанарыг нэмэгдүүлж, ашгийн удирдлагыг бууруулахтай холбоотой дараах саналыг дэвшүүлж байна.

1. Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тэдний мэдлэг туршлагыг компанидаа нэвтрүүлснээр хяналтыг сайжруулж, ашгийн удирдлагыг бууруулах.
2. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд менежерүүдийн хувийн ашиг сонирхлыг бууруулахын тулд дотоод хяналтын систем болон механизмуудыг сайжруулах хэрэгтэй.
3. Зөвхөн хувьцаат компаниуд бус хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын мэдээлэлд судалгаа хийснээр Монгол улсын хэмжээнд ашгийн удирдлагыг тодорхойлох, түүний учир шалтгааныг илрүүлэх боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Г.Гантулга. (2018). Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг үнэлэх нь. *Бизнесийн менежментийн ухаан Докторын зэрэг горилсон диссертаци*, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль.
- С.Цэвээнжаргал. (2021). Хувьцаат компаниудын ашгийн удирдлагыг хэмжих. *Бизнесийн удирдлагын магистрын зэрэг горилсон бүтээл*, Мандах их сургууль.
- Akerlof, G. A. (1970). The Market for "Lemons": Quality Uncertainty and the Market Mechanism. *The Quarterly Journal of Economics*, Vol. 84, No. 3, 488-500.
- Alves, S. (2012). Ownership Structure and Earnings Management: Evidence from Portugal. *Australasian Accounting, Business and Finance Journal*, 6(1), 57-74.
- Bao, S. R., & Lewellyn, K. B. (2017). Ownership structure and earnings management in emerging markets—An institutionalized agency perspective. *International Business Review*, Volume 26, Issue 5, 828-838.
- Beest, F. V., Braam, G., & Boelens, S. (2009). Quality of financial reporting: measuring qualitative characteristics. *NiCE Working Paper 09-108*.
- Dechow, P. M., Sloan, R. G., & Sweeney, A. P. (1996). Causes and Consequences of Earnings Manipulation: An Analysis of Firms Subject to Enforcement Actions by the SEC. *Contemporary Accounting Research*, Volume 13, Issue 1, 1-36.
- Farooq, O., & Jai, H. E. (2012). Ownership Structure and Earnings Management: Evidence from the Casablanca Stock Exchange. *International Research Journal of Finance and Economics* 84, 95-105.
- Gaio, C., & Pinto, I. (2018). The role of state ownership on earnings quality: evidence across public and private European firms. *Journal of Applied Accounting Research*, Emerald Group Publishing Limited, vol. 19(2), 312-332.
- Guo, F., & Ma, S. (2015). Ownership Characteristics and Earnings Management in China. *Chinese Economy*.
- Hair, J. F., Black, W. C., Babin, B. J., & Anderson, R. E. (2006). *Multivariate Data Analysis*. Pearson International.
- Jensen, M. C., & Meckling, W. H. (1976). Theory of the Firm: Managerial Behavior, Agency Costs and Ownership Structure. *Journal of Financial Economics*, Vol. 3, No. 4, 305-360.
- Jones, J. J. (1991). Earnings Management During Import Relief Investigations. *Journal of Accounting Research*, Vol. 29, No. 2, 193-228.
- Khanna, T., & Palepu, K. (2000). Is Group Affiliation Profitable in Emerging Markets? An Analysis of Diversified Indian Business Groups. *The Journal of Finance*, Vol.55, Issue 2, 867-891.
- Nguyen, H. A., Le, Q. L., & Vu, T. K. (2021). Ownership structure and earnings management: Empirical evidence from Vietnam. *Cogent Business & Management*.
- Shleifer, A., & Vishny, R. W. (1997). A Survey of Corporate Governance. *The Journal of Finance*, Volume 52, Issue 2, 737-783.
- Warfield, T. D., Wild, J. J., & Wild, K. L. (1995). Managerial ownership, accounting choices, and informativeness of earnings. *Journal of Accounting and Economics* 20, 61-91.

ИНФЛҮҮНСЭР МАРКЕТИНГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

(Европын Холбооны улсуудын жишээн дээр)

Б.Золзаяа¹

Мандах ИС, ЭЗБТ, Багш

zolzaya@mandakh.edu.mn

Хураангуй

Техник технологийн хөгжилд суурилсан нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлт нь олон улсад хууль эрх зүйн шинэ тутам зохицуулалтуудыг шаардах болсны нэг нь инфлүүнсэр маркетингийн асуудал юм. Учир нь өнөө цагт инфлүүнсэр хэмээх онлайн орчинд хэдэн зуугаас эхлэн хэдэн саяар тоологдох дагагчтай хүмүүс бий болж, тэд нэг улс үндэстний төдийгүй олон улсын хэмжээнд хүн ард, хэрэглэгчдэд нөлөө үзүүлэх болсон. Гэвч гол асуудал нь нэг талаас, инфлүүсэрүүдийг хуулийн хүрээнд дэмжих, нөгөө талаас, тэдний түгээж, нөлөөлж буй зүй бус мэдээллээс хэрэглэгчид хохирохоос урьдчилан сэргийлэх юм. Өөрөөр хэлбэл, инфлүүсэр маркетингийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал олон улсад чухлаар тавигдах болсон билээ. Иймд дэлхийн олон оронд, тэр дундаа хөгжингүй орнуудаас эхлэн инфлүүнсэр маркетингийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоход ихэд анхаарах болсон юм. Үүнд Европын Холбооны улсууд нь дижитал орчны эрх зүйн зохицуулалтаар дэлхийд сайн туршлагад тооцогддог. Иймд тус өгүүллэгээр Европын Холбооны гишүүн улс орнуудын инфлүүнсэр маркетингийн хууль, эрх зүйн зохицуулалтын талаар судалж, нэгтгэн танилцуулахыг зорив.

Түлхүүр үг: дижитал маркетинг, инфлүүнсэр, Европын Холбоо, эрх зүйн зохицуулалт

ОРШИЛ

Инфлүүнсэр гэдгийг онлайн орчинд Instagram, Facebook, YouTube, Twitter, TikTok зэрэг олон нийтийн мэдээллийн платформыг ашиглан тухайн салбаруудад танигдсан хувь хүн гэсэн ойлголт түгээмэл байдаг. Гэвч энэ нь илүү өргөн цар хүрээнд авч үзэх ойлголт юм. Учир нь бодит байдалд инфлүүнсэр нь хувь хүн, байгууллага, амьтан байхаас гадна хиймэл оюун ухаан болон бусад технологийн дэвшлийг ашиглан виртуаль инфлүүнсэр, аватар, дижитал дүр зэрэг эд зүйлийн буюу бодит хүн бус инфлүүнсэрүүдийг үүсгэх болсон юм. Иймд өнөөдөр судлаачид инфлүүнсэрийн бүх талыг хамарсан нэгдсэн нэг тодорхойлолтод хараахан хүрээгүй байна².

Харин “инфлүүнсэр маркетинг” (influencer marketing) гэдэг нь тэдгээр инфлүүнсэрийг ашиглаж технологийн дэвшлийн үндсэн дээр бий болсон дижитал орчин дахь зар сурталчилгааны нэг хэлбэр юм. Сүүлийн үед зар сурталчилгаа захиалагч, бүтээгчид нь инфлүүнсэр маркетингийг зорилтот хэрэглэгчдэд мэдээллийг хүргэх, тэднийг худалдан авалтад хөтлөх хамгийн оновчтой аргуудын нэг хэмээн үзэх болсон нь энэ төрлийн зар сурталчилгааг хурдтай тэлэхэд хүргэж байна. Үүнийг дэлхийн зар сурталчилгаан дахь инфлүүнсэр маркетингийн зах зээл 2016 онд 1.7 тэрбум ам.доллар байсан бол 6 жилийн дараа буюу 2022 онд 28 тэрбум ам.долларт хүрсэн³ өсөлттэй байгаагаас харж болно.

Инфлүүнсэр маркетингийн зар сурталчилгааны хүрээнд бусдад тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авалт хийх сэдэл төрүүлэх, худалдан авахад ятгах, худалдан авалтын дараах үр дүнг сайн байх болно хэмээн итгүүлэх үйл явц өрнөдөг. Гэвч энэ харилцаанд тодорхой бус, эсвэл инфлүүнсэрүүд нь өөрийн нэр хүндийг ашигласан ёс зүйгүй, хариуцлагагүй, хууль бус үйл ажиллагаа үйлддэг нь энэ асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулах гол шаардлагыг буй болгодог. Тэгвэл Европын Холбооны ихэнх улсууд энэ асуудалд шууд анхаарал хандуулж тусгай хууль, дүрэм, зөвлөмж, гарын авлага зэргийг батлан хэрэгжүүлж байна. Иймд тэдгээр улсуудын инфлүүнсэр маркетингийн эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах нь сүүл үед манай улсын зар сурталчилгааны зах зээлд түгээмэл хэрэглэгдэх болсон инфлүүнсэр маркетингийн эрх зүйн зохицуулалтын судалгаанд чухал ач холбогдолтой юм.

Гэвч манай улсад Европын Холбооны улсуудын инфлүүнсэр маркетингийн эрх зүйн зохицуулалтын талаар судалсан нь төдий л хомс юм. Тэрчлэн гадаадад энэ тухай өмнө нь хийгдсэн судалгаануудад энэ сэдвээр Европын холбооны улсуудыг бүхэлд нь авч үзсэн судалгаа ч бас хомс бололтой. Магадгүй би энэ удаа хайгаад олж чадаагүй байхыг үгүйсгэхгүй. Харин 2022 онд Европын Парламент нь инфлүүнсэр маркетингийн үйл ажиллагаанд хэрэглэгчийг хамгаалах талаарх судалгааны тайлан⁴, Европын Зар Сурталчилгааны Стандартын Холбоо⁵ нь инфлүүнсэр маркетингийн сайн туршлагын талаарх зөвлөмжийг 2018 болон 2023 онуудад хэвлүүлсэн байна.

Иймээс тус ажлаар Европын Холбооны улсуудын засгийн газрын цахим хуудаснууд дахь инфлүүнсэр маркетингийн эрх зүйн зохицуулалтын талаарх албан ёсны мэдээлэлд индуктив контент анализын аргыг хэрэглэж чанарын судалгаа хийхийг зорив. Индуктив

² Sylvia Chan-Olmsted, Hyehyun Julia Kim Influencer marketing dynamics: The roles of social engagement, trust, and influence, p.99-122

³ <https://www.statista.com/study/132109/advertising-report-influencer-advertising/>

⁴ European Parliament (2022). The impact of influencers on advertising and consumer protection in the Single Market: [https://www.europarl.europa.eu/thinktank/en/document/IPOL_STU\(2022\)703350](https://www.europarl.europa.eu/thinktank/en/document/IPOL_STU(2022)703350)

⁵ EASA, (2023). Best Practice Recommendation on Influencer Marketing Guidance. https://www.easa-alliance.org/publications/best-practice-recommendation-on-influencer-marketing-guidance_v2023/

контент анализын арга нь урьдчилан төсөөлөөгүй ангилал, онолгүйгээр тус тусдаа байгаа өгөгдлийг цуглуулж, дүн шинжилгээ хийж нэгтгэн ерөнхий дүгнэлт гаргах арга юм⁶. Хайгуул шинжилгээний тус арга нь шинээр гарч ирж буй хэв маяг, үзэгдэл, үзэл баримтлалыг тодорхойлоход илүүтэй тохирдог тул сонгосон болно. Тус өгүүллийг нэг, “Европын Холбооны улсуудын инфлүүнсэр маркетингийн хууль, эрх зүйн зохицуулалтын нөхцөл байдал”, хоёр, “инфлүүнсэр маркетингийн ёс зүйн дүрмүүд болон францын хуулийн тухай” гэсэн хоёр хэсэгт хуваан өгүүлэв.

НЭГ. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУДЫН ИНФЛҮҮНСЭР МАРКЕТИНГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Европын Холбоо нь одоогийн байдлаар 27 гишүүн улстай бөгөөд Европын Холбооноос 2018 онд “Дижитал үйлчилгээний тухай” хууль⁷ баталж дижитал орчин дахь бүтээгдэхүүн үйлчилгээний зар сурталчилгаа, тэр дундаа инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулах болсон юм. Гэвч Европын Холбооны улсуудын инфлүүнсэр маркетингийн зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтууд нь нэгэн ижил биш хэд хэдэн төрлийн эрх зүйн хэм хэмжээний актуудаар зохицуулж буй байдал ажиглагдаж байна. Мөн инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулах хуулийн заалтыг хэрэгжүүлэх төрийн чиг үүрэг бүхий хоёр төрлийн байгууллагууд ажиллаж байна. Иймд энэ талаар тойм авч үзье.

Эрх зүйн хэмжээний актуудын тухай. Европын Холбооны улсуудаас Бүгд Найрамдах Румын Улс болон Бүгд Найрамдах Кипр Улсын хувьд инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулсан тусгай эрх зүйн хэм хэмжээний акт батлаагүй бөгөөд энэ харилцааг “зар сурталчилгааны тухай хууль”-иар зохицуулж байна. Өөрөөр хэлбэл, энэ хоёр улсын хувьд “зар сурталчилгааны тухай хууль”-даа инфлүүнсэрүүд болон инфлүүнсэр маркетинг гэдэг үгийг ашигласан, эсвэл тусгайлсан хууль зүйн нэр томъёо, тодорхойлолт өгсөн энэ төрлийн харилцааны зохицуулалт байхгүй байна. Энэ нь харьцуулбал Монгол улстай ижил байгаа юм.

Харин нэр бүхий 24 улсууд нь хэвлэл мэдээллийн, маркетингийн, зар сурталчилгааны болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай зэрэг холбогдох хуулиуддаа инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулсан нэмэлт, өөрчлөлт оруулж энэ төрлийн зар сурталчилгааны эрх зүйн харилцааг зохицуулж байна. Эдгээр 24 улсаас 10 улс нь холбогдох хууль дахь инфлүүнсэр маркетингийн тухай заалтуудыг хэрхэн мөрдөж ажиллах талаар инфлүүнсэрүүдэд зориулсан тусгай зөвлөмж, гарын авлага, ёс зүйн дүрэм зэрэг ёс зүйн эрх зүйн актууд гарган хэрэгжүүлэх болсон байна. Ингэснээрээ тэдгээр улсын инфлүүнсэр маркетингийн зах зээлийн эрх зүйн орчин илүү боловсронгуй болсныг тэмдэглүүштэй юм. Жишээлбэл, Унгар улс 1996 онд баталсан “Шударга бус харилцааны тухай” хуулиараа инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулах боловч хуульд заасны дагуу инфлүүнсэрүүдийн зар сурталчилгаанд зөвшөөрсөн болон эс зөвшөөрсөн үйл ажиллагааны талаар “#GVH#Compliance#Influencer” хэмээх зөвлөмжийг⁸ 2017 онд гаргасан байна. Мөн Польш улс “Өрсөлдөөн ба хэрэглэгчийг хамгаалах тухай” хуулиар инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулдаг хэдий ч 2022 онд инфлүүнсэрүүдийн дагаж мөрдөх тусгай зөвлөмж⁹ гаргаж, түүндээ практик

⁶ Neuendorf, K.A. (2001). The Content Analysis Guidebook.

⁷ An official website of the European Union: <https://eur-lex.europa.eu/eli/reg/2022/2065/oj> (2023.12.10)


⁸ https://www.gvh.hu/pfile/file?path=/en/actualities/aktualis_hirek_gvh_megfeleles_velemenyezer_2017_11_30_a&inline=true (Бүгд Найрамдах Унгар Улсын Өрсөлдөөнийг Зохицуулах Газар)

⁹ https://uokik.gov.pl/aktualnosci.php?news_id=18898 (Бүгд Найрамдах Польш Улсын Өрсөлдөөн,

Хэрэглэгчийн төлөө газар)


жишээнүүдийг тусгаж өсгөн байна. Харин Австри, Бельги, Чех, Словак, Испани улсууд нь инфлүүнсэрүүдийн дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг боловсруулжээ. Тэдгээр ёс зүйн дүрмүүдийг зар сурталчилгааны эсвэл хэрэглэгчийг хамгаалах хуулиудын зүйл, заалтад үндэслэсэн байна.

Франц Улс “Дижитал сурталчилгааны харилцаа” нэртэй дүрмийг¹⁰ 2018 онд батлан хэрэгжүүлж байсан бол 2023 онд “Арилжааны нөлөөллийг зохицуулах, нийгмийн сүлжээн дэх нөлөөлөгчдийн хэт их үйл ажиллагаатай тэмцэх тухай” хуулийг¹¹ баталсан нь Европын Холбооны улсуудаас энэ төрлийн харилцааг тусгай хуулиар зохицуулах болсон анхны улс болжээ. Дээр өгүүлсэнд үндэслэн Европын Холбооны улсуудын инфлүүнсэр маркетингийн хууль, эрх зүйн зохицуулалтыг дөрвөн хэсэгт хуваан ангилснаа зургаар үзүүлье.



Зураг 1. Европын Холбооны улсуудын инфлүүнсэр маркетингийн эрх зүйн зохицуулалтын байдал

Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагуудын тухай. Европын Холбооны орнуудад инфлүүнсэр маркетингийн харилцааг уламжлалт зар сурталчилгааны хуулиар болон холбогдох хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зохицуулж байгаатай холбоотой хуульд заасан төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай байгууллагууд ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулах хуульд заасан төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд 13 улсад “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийг хамгаалах байгууллага”, 14 улсад нь “Зар сурталчилгаа хариуцсан байгууллага” хариуцан хууль эрх зүйн хяналтыг тавьж ажиллаж байна. Үүнийг зургаар үзүүлбэл:



Зураг 1. Инфлүүнсэр маркетингийн харилцааг зохицуулах төрийн чиг үүрэг бүхий хоёр төрлийн байгууллага ба улсууд

¹⁰ https://www.arpp.org/nous-consulter/regles/regles-de-deontologie/recommandation-communication-publicitaire-numerique/#toc_1_2 (Франц Улс, Зар Сурталчилгааны мэргэжлийн зохицуулах байгууллага)

¹¹ <https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT000047663185>

Дээрх зурагт үзүүлсэн Чех¹², Словак¹³ улсуудын Зар сурталчилгаа хариуцсан өөрөө удирдах байгууллагаас инфлүүнсэрүүдэд зориулсан онлайн платформ ажиллуулдаг нь төрийн байгууллагын цахим дэд бүтцийн шинэ туршлага болж байна. Тус хоёр улсын хувд ёс зүйн дүрмээ хэрэгжүүлэхдээ онлайн платформ ашигладаг бөгөөд, тус платформоор ёс зүйн дүрмийн талаар мэдээлэл өгөх, инфлүүнсэрүүд, зар сурталчилгааны агентлагууд, захиалагч брэндүүдийг ёс зүйн кодонд гарын үсэг зуруулж бүртгэх, платформоор дамжуулан тэднийг нийгмийн хариуцлагатай гэдгийг иргэдэд таниулах мөн иргэдээс хууль зөрчсөн инфлүүнсэр маркетингийн зар сурталчилгааны талаар гомдол хүлээн авах ажлуудыг зохион байгуулж байна.

Харин инфлүүнсэрүүдийн хувьд тус платформд бүртгэлтэй байснаар хууль, дүрмийг дагаж нийгмийн хариуцлагатай байхаас гадна тэдний мэдээлэл тус платформд байршсанаар гадаад болон дотоодын захиалга нэмэгдэх боломж бүрддэг байна. Иймд Чех, Словак улсуудын харьяа төрийн байгууллага нь инфлүүнсэр маркетингийг зохицуулах платформ буюу цахим дэд бүтцийг үүсгэсэн нь дижитал орчинд өрнөдөг инфлүүнсэр маркетингийн харилцааг зөв зохистой удирдахад томоохон ахиц дэвшил авчирч чадсан хэмээн харж байна.

ХОЁР. ИНФЛҮҮНСЭР МАРКЕТИНГИЙН ЁС ЗҮЙН ДҮРМҮҮД БОЛОН ФРАНЦЫН ХУУЛИЙН ТУХАЙ

Энэ хэсэгт Австри, Бельги, Чех, Испани улсуудын инфлүүнсэр маркетингийн ёс зүйн дүрэм, түүн дэх зарим онцлог зүйл, заалт болон Франц улсын шинээр баталсан тусгай хуулийн талаар товчхон танилцуулав.

Австрийн ёс зүйн дүрэм 3 зүйл, Чехийн ёс зүйн дүрэм 7 зүйлтэй, Бельгийн ёс зүйн дүрэм 10 зүйлтэй, Испаний ёс зүйн дүрэм 5 бүлэг 17 зүйлтэй, Франц улсын хууль нь 2 бүлэг 18 зүйлтэй байна.

Австри улсын ёс зүйн дүрмийн тухай. Инфлүүнсэр маркетингийн ёс зүй, ёс суртахууны удирдамжийн хувьд Австрийн “Зар сурталчилгааны зөвлөл”-өөс эрхлэн 2021 онд гаргасан “Зар сурталчилгааны салбарын ёс зүйн дүрэм”¹⁴-ийг баримтлах бөгөөд тус дүрмийн 1.8-д инфлүүнсэр маркетингийн тухай зааж өгчээ. Тус дүрэмд зар сурталчилгааны компаниуд зар сурталчилгааны захиалга өгөх эсвэл төлбөр төлөх үед нийгмийн мэдээллийн сувгууд дахь харилцаа холбоонд шууд нөлөөлдөг тул инфлүүнсэрүүдээс гадна зар сурталчилгааны компаниуд үйлчлүүлэгчдийн өмнө хариуцлага хүлээхийг зааж өгсөн бөгөөд инфлүүнсэрүүд нь ялангуяа 18 нас хүртэлх хэрэглэгчдэд хариуцлагатай, үлгэр дуурайлтай байхыг чухалчилсан байна. Түүнчлэн 1.8.1-д хүүхэд залуучуудад шууд чиглэсэн сурталчилгааны хувьд сурталчилж буй бүтээгдэхүүнийг худалдан авахыг ил болон далд уриалга гаргаж болохгүй хэмээн заасан байдаг. Сурталчилгаа хийхдээ эрүүл мэндэд хортой зан үйл, эрүүл мэнд, бие махбодид хор учруулахуйц бие махбодийн хортой хэлбэр, хэмжээг (биеийн жин) сурталчлахгүй байх ёстой. Мөн сэтгэлзүйн болон нийгмийн хүчирхийлэл гаргасан үйлдэл гаргахгүй байх бөгөөд үүнд хувь хүн, бүлгүүдийг үл тоомсорлох, доромжлох, заналхийлэх, айдас төрүүлэх, цаашлаад “тоглох (pranking)” гэх мэт үйлдлүүд багтана.

Бельги улс. 2018 онд анх Бельги улсын Харилцаа холбооны газраас инфлүүнсэрийн талаарх зөвлөмж боловсруулж байсан бол 2021 онд ёс зүйн дүрэм¹⁵ шинээр гаргасан

¹² <https://ferovyinfluencer.cz/> (Бүгд Найрамдах Чех Улс, Интернет Хөгжлийн Холбоо)

¹³ <https://kodexinfluencermarketingu.sk/> (Бүгд Найрамдах Словак Улс, Интерактив зар сурталчилгааны хороо)

¹⁴ https://werberat.at/layout/ETHIK_KODEX_1_2021_END.pdf

¹⁵ https://www.jep.be/wp-content/uploads/2022/04/influencers_FR.pdf

байна. Тус ёс зүйн дүрэмд инфлүүнсэр маркетингийн бизнесийн харилцаа үүссэн хэмээн үзэх 8 нөхцлийг нарийвчлан зааж инфлүүнсэр нь захиалагчтай тогтоосон харилцаагаа ил тод байлгаж шударгаар “төлбөртэй” гэсэн шошго тавихыг шаарддаг. Учир нь тухайн контентоос болж үүсэх хариуцлагыг инфлүүнсэр үүрдэг байна. Мөн ёс зүйн дүрэмд хүүхдэд чиглэсэн зар сурталчилгаа, согтууруулах ундаа агуулсан ундаа болон хоол хүнс, машин, гоо сайхны бүтээгдэхүүн, азын тоглоом гэх мэт бүтээгдэхүүнийг сурталчлах тал дээр онцгой анхаарахыг сануулсан байдаг.

Чех улс. Зар сурталчилгааны тухай хуулийг дагаж мөрдөх ба инфлүүнсэрүүд ямар нэгэн брэнд эсвэл компаниас бүтээгдэхүүнээ өгч контентэнд оролцуулсан бол өөрсдөө худалдаж авсан дүр эсгэх ёсгүй хэмээн зар сурталчилгаагаа шошголох ёстой¹⁶. Мөн инфлүүнсэрүүд бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой туршлагаа худал хэлэх эсвэл нуух ёсгүйгээс гадна инфлүүнсэр, брэнд, агентлагууд нь зар сурталчилгааг зохицуулах байгууллагын анхааруулгыг дагаж, таагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд засаж залруулах үүрэгтэй байдаг. Инфлүүнсэр, брэнд, агентлагууд нь хэрэв тухайн инфлүүнсэрийн үзэгчдийн 25-аас дээш хувь нь насанд хүрээгүй хүмүүсээс бүрддэг бол архи, тамхи, мөрийтэй тоглоом зэрэг сурталчлах хориотой эсвэл зохицуулалттай бүтээгдэхүүнийг сурталчлах боломжгүй юм.

Испани улс. Тус улсын хувьд компани буюу инфлүүнсэрүүдэд захиалга өгч үйлчилгээ авч буй талын үүргийг чухалчилж авч үзсэн бөгөөд тэд энэ ёс зүйн дүрмийг¹⁷ мөрдөхийн тулд дотоод хяналтыг хэрэгжүүлэх ёстой хэмээжээ. Мөн контентийн агуулгад хяналт тавиад эргэлзэх зүйл гарсан тохиолдолд зар сурталчилгааг хариуцсан байгууллагын техникийн албанд контентийн агуулгыг илгээж урьдчилан хянуулж журмын дагуу ажиллах боломжийг бүрдүүлсэн ажээ. Инфлүүнсэр маркетингийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавихдаа иргэдийн хяналт, захиалагч компанийн дотоод хяналт, төрийн байгууллагын хяналтын хороо гэсэн гурван оролцогч талуудыг хамруулахаар заасан байна.

Франц улсын хууль. Францын “Зар Сурталчилгааны Мэргэжлийн Өөрийгөө Зохицуулах байгууллага” (ARPP) нь анх 2010 онд бүх төрлийн дижитал сурталчилгааны харилцаанд нийтлэг дүрмийг зааж өгсөн “Дижитал зар сурталчилгааны харилцааны зөвлөмж”-ийг гаргаж улмаар 2017 онд дахин шинэчилсэн байдаг. Харин 2023 онд инфлүүнсэр маркетингийн “Арилжааны нөлөөллийг зохицуулах, нийгмийн сүлжээн дэх инфлүүнсэрүүдийн хэт их үйл ажиллагаатай тэмцэх”¹⁸ тухай 2 бүлэг, 18 зүйлтэй хуулийг баталжээ. Тус хууль нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр согтууруулах ундаа, санхүүгийн бүтээгдэхүүн, спортын бооцоо тавих, гоо сайхны эм, мэс засал, эрүүл мэндийн процедурыг сурталчлах, никотиныг сурталчлах, эмчилгээнээс татгалзахыг уриалах (эмчилгээг зогсоох эсвэл орлуулахыг зөвлөх)¹⁹-ыг сурталчлахыг хориглосон заалтуудтай.

“Арилжааны нөлөөллийг зохицуулах, нийгмийн сүлжээн дэх нөлөөлөгчдийн хэт их үйл ажиллагаатай тэмцэх” тухай хуулийн эхэнд тус хууль нь нэгдүгээрт, инфлүүнсэрүүдийг дэмжих, хоёрдугаарт хэрэглэгчдийг хамгаалах гэсэн хоёр үндсэн чиг үүрэгтэй хэмээн бичсэн байна.

¹⁶ <https://ferovyinfluencer.cz/kodex>

¹⁷ <https://www.autocontrol.es/wp-content/uploads/2020/10/codigo-de-conducta-publicidad-influencers.pdf>

¹⁸ https://www.legifrance.gouv.fr/jorf/article_jo/JORFARTI000047663204

¹⁹ Францын Засгийн газар “Еховагийн гэрчүүд” болон бусад шинэ шашны гаж урсгалуудын аливаа өвчин, ослоос болж амь эрсдэх хэмжээнд ирсэн ч эмнэлгийн үйлчилгээнээс татгалзах, цус сэлбэхгүй байх, цэргийн алба хаахгүй байх, улс төрийн сонгуульд санал өгөхгүй байх зэргийг уриалдаг хууль эрхзүйн зөрчилтэй сургаал номлолыг иргэдэд сэрэмжлүүлэх идэвхжүүлэлтийн ажлыг 1995 оноос хойш тасралтгүй хийж ирсэн.

Инфлүүнсэрүүдийг дэмжих хэсэгт насанд хүрээгүй инфлүүнсэрүүдийн хөдөлмөр хамгааллын заалтууд багтаж, тэдний инфлүүнсэрийн үйл ажиллагаанаас олох орлогыг насанд хүрэх хүртэл нь төр хамгаалалтандаа авах бөгөөд насанд хүрээгүй инфлүүнсэрүүдийн орлогын 90%-иас багагүй хэсгийг эцэг эх, асран хамгаалагчид холбогдох газрын нийгмийн байцаагч нарт мэдэгдэх шаардлагатайг зааж өгсөн. Мөн энэ хэсэгт брэндүүд, агентлаг, инфлүүнсэрүүдийн хооронд гэрээ байгуулахдаа заавал бичгэн хэлбэртэй байх үүрэг оруулж өгсөн нь цөөн тооны дагагч нартай жижиг инфлүүнсэрүүдийг²⁰ хохирч үлдэхээс хамгаалахад чиглэгдсэн байна. Тус хуулинд инфлүүнсэр маркетинг хийхэд зориулсан “Сайн туршлагын хөтөч” хэмээх 20 хуудастай зөвлөмжийг инфлүүнсэрүүд, агентлаг, брэндүүдэд тараах материал хэлбэрээр, онлайнар түгээх идэвхжүүлэлтийн ажлыг, хариуцлагатай нөлөөллийн бага хурлыг жил бүр зохион байгуулахаар зааж өгсөн байна.

Энэхүү хуулийн хоёр дахь чиг үүрэг нь хэрэглэгчдийг, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхнийг хамгаалахаас бүрддэг ба тус чиг үүргийн хүрээнд “Арилжааны нөлөөллийн хороо”-г яаралтай байгуулахаар тусгасан. Тус хороог “Өрсөлдөөн, хэрэглэгчийн асуудал, залиланг хянах ерөнхий газар” (DGCCRF)-т 15 төлөөлөгчтэйгээр байгуулж нийгмийн сүлжээг хянах, “Signal Conso”²¹ дээр хүлээн авсан мэдээллүүдийг шалгаж, хариу өгөх, мэдээлэл үндэслэлтэй бол зохих шийтгэл оногдуулах үүргийг олгосон байна. Тодруулбал, энэ хороо нь бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран хориг арга хэмжээ авах, инфлүүнсэрийн нийгмийн сүлжээний дансыг хаах, зөрчил гаргасан тохиолдолд шаардлагатай бол асуудлыг шүүх рүү шилжүүлэх эрхтэй. Инфлүүнсэрүүдийн хувьд хэрэглэгчдийг хамгаалах тухай асуудал дээр засварласан видео, дүрсийг ил тодоор “Засварласан” хэмээн шошголох, нүүр царай, дүрсийг дүрслэх зорилготой хиймэл оюун ухааны аливаа процессоор бүтээгдсэн зургуудад "Виртуал зураг" гэсэн шошго заавал тавих үүргүүдийг хүлээлгэхээр оруулж өгчээ.

Дүгнэж хэлбэл тус хуулинд инфлүүнсэр маркетингийн салбар дахь даатгал, татвар, гадаадын инфлүүнсэрүүдийн хариуцлага гээд олон шинэ асуудлуудын талаарх зохицуулалтуудыг тусгаж өгсөн нь дэлхийд анх удаа бөгөөд багагүй ахиц дэвшлийг бий болгосон юм. Жишээлбэл, гадаад улсад байдаг инфлүүнсэрүүд хэрвээ францийн хэрэглэгч нарт чиглэсэн үйл ажиллагаа явуулах бол нөлөөллийн ажлын гэрээгээ Францын хууль тогтоомжид нийцүүлэн баталгаажуулах, төрийн эрх бүхий захиргааны байгууллагын хүсэлтэд хариу өгөх үүрэгтэй хууль ёсны төлөөлөгчтэй болох шаардлагуудыг гарган тавьснаар гадаад улс дахь инфлүүнсэр нь хууль бус үйлдэл хийсэн тохиолдолд францийн талаас хариуцлага хүлээлгэх боломжтой эрх зүйн нөхцөл бүрдэж байгаа юм.

²⁰ Инфлүүнсэрүүдийг нано инфлүүнсэр буюу 1000-аас цөөн дагалдагчтай, микро инфлүүнсэр буюу 1000-100.000 дагалдагчтай, макро инфлүүнсэр буюу 100.000-1.000.000 дагалдагчтай, мега инфлүүнсэр буюу 1.000.000-аас дээш дагалдагчтай хэмээн дагагчдын тоогоор нь ангилдаг.

²¹ Signal Conso нь Хэрэглэгчийн асуудал, өрсөлдөөн, залилангаас урьдчилан сэргийлэх ерөнхий газрын (DGCCRF) олон нийттэй харилцахаар нэвтрүүлсэн гар утасны аппликейшнд суурилсан үнэ төлбөргүй үйлчилгээ бөгөөд хэрэглэгчид ёс зүйн зөрчилтэй контентуудын талаар төрд мэдээлэх боломжийг олгодог.

ДҮГНЭЛТ

Инфлүүнсэр маркетингийн зар сурталчилгаанд оролцогч талууд болох инфлүүнсэр, хэрэглэгч, зар сурталчилгаа захиалагчийн эрх, үүргийг тодорхойлж, энэ төрлийн бизнесийн харилцааг хэрхэн зохицуулахыг хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээний актуудаар хэрэгжүүлэх нь тус салбарыг хууль ёсны, ёс зүйтэй хөгжих нөхцлөөр хангах, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүллээр Европын Холбооны улсуудын инфлүүнсэр маркетингийн хууль эрх зүйн зохицуулалтууд болон хуульд заасан төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагуудын талаарх мэдээллийг товч танилцуулав. Үүнээс үзвэл, Европын Холбооны улсуудын инфлүүнсэр маркетингийн талаар гаргасан дийлэнх ёс зүйн дүрэм, хуулийн үндэслэгээ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжид тулгуурласан шинжтэй байна. Инфлүүнсэр маркетингийг зохицуулах хууль, дүрмийн агуулгад ихэвчлэн дараах асуудлуудыг хөнджээ. Үүнд:

- Далд зар сурталчилгааг хориглож, төлбөртэй контент гэдгээ ил тод, шударгаар зарлах, засварлагдсан зураг, бичлэг эсвэл хиймэл оюун ухаанаар бүтээсэн зураг, бичлэг, дүр зэргийг шошголох;
- Согтууруулах ундаа, санхүүгийн бүтээгдэхүүн, спортын бооцоо тавих, гоо сайхны мэс засал, эмнэлгийн үйлчилгээ авахаас татгалзах, бусдыг ялгаварлан гадуурхах, эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүн, үйл, үйлдлийг сурталчилсан зэрэг контентийн ёс зүйн зөрчилтэй агуулгуудыг тодорхойлох, сурталчлахыг хориглосон эсвэл тодорхой зохицуулалттайгаар сурталчлах бүтээгдэхүүн, салбар, үйлдэл, үйл ажиллагааг тодорхойлж инфлүүнсэр болон захиалагч талын зөв зан үйл, үйл ажиллагаа явуулах нөхцлийг нарийн зааж өгөх;
- Инфлүүнсэрүүд нь өөрийн дагалдагчдын статистикийг ажиглаж хүүхэд залуучуудад чиглэсэн эсвэл тэд үзэж болох контент хийх бол агуулгад анхаарах, хэрвээ насанд хүрээгүй хүмүүс үзэх ёсгүй хүчирхийллийн гэх мэт шинжтэй агуулгатай бол агуулгын талаар анхааруулга тавих, насны хязгаарыг заах тал дээр хариуцлагатай хандах;
- Инфлүүнсэрүүд нь зөрчилтэй контент бүтээх, илүү их захиалга авах эсвэл илүү алдар нэртэй болохын төлөө хийж болох бусад гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг (жишээлбэл дагалдагчдын тоог хуурамчаар нэмж залилах) нарийн зааж хариуцах эрх, үүрэг бүхий байгууллагатай болох;
- Инфлүүнсэр маркетингийн ёс зүйн хариуцлагын тухай асуудлыг инфлүүнсэрүүд, зар сурталчилгааны агентлаг, компаниудын хамтын оролцоог хангасан санаачлага хэлбэрээр танилцуулж, түүнийгээ вебээр дамжуулан бүртгэх, үүрэг хариуцлага, хамтын ажиллагаатай холбох;

Улс орнуудын зүгээс инфлүүнсэрүүдийг бүртгэж ёс зүйн дүрэмтэй танилцуулж гарын үсэг зуруулан үүрэг хариуцлагад сургах, ёс зүйн дүрмээр сургалт явуулж гэрчилгээ олгох, тэдний үйл ажиллагаа хууль, дүрмийг зөрчиж байгааг хяналтын хороо болон иргэдээр хянуулах үйл ажиллагаануудыг түгээмэл явуулж байна. Харин манай улсын хувьд инфлүүнсэр маркетингийн үзэгдэл хэдэн жилийн өмнөөс эрчимтэй хөгжиж байгаа ч энэ чиглэлээр төрийн эрх баригчдын шийдвэр гаргалт практикт хоцрогдсон хэвээр

байна. Иймээс манай улс инфлүүнсэр маркетингийн харилцааг тусгайлсан хууль батлах, эсвэл холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар зохицуулах, инфлүүнсэрүүд хууль, дүрмийг дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх, инфлүүнсэр маркетингийн харилцааг хянах болон хэрэглэгчийн эрхийг хангахад туслах дижитал хэрэгслийг хөгжүүлэх, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох хэрэглэгчийн туршлага, зан үйлийн судалгааг тодорхой давтамжтай хийж баталгаажуулдаг болох хэрэгтэй юм.

ЭШЛЭСЭН ЭХ СУРВАЛЖ

1. José M. Álvarez-Monzoncillo, (2022). The Dynamics of Influencer Marketing A Multidisciplinary Approach. London. 99-122x
2. Европын Парламент, (2022). The impact of influencers on advertising and consumer protection in the Single Market.
3. EASA, (2023). Best Practice Recommendation on Influencer Marketing Guidance.
4. Neuendorf, K.A. (2001). The Content Analysis Guidebook.

НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙ ЯЛГАРУУЛАЛТ НЬ ҮНДЭСНИЙ ТОДОРХОЙЛСОН ХУВЬ НЭМРИЙН ЗОРИЛТОД ХҮРЭХ ТААМАГЛАЛ

З. Түшигмаа^{1a}, Г. Энх-Отгон^{2b}, А. Наранцэцэг^{3c}

¹Мандах ИС, НББ хөтөлбөрийн оюутан

²Мандах ИС, БШТ, Багш

³Мандах ИС, А. Наранцэцэг, (PhD) дэд профессор

^aat20d061@mandakh.edu.mn

^benkhotgon@mandakh.edu.mn

^cnarantsetseg@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Дэлхийн уур амьсгал хүн төрөлхтний буруутай үйл ажиллагаанаас үүдэн өөрчлөгдөж, нүүрстөрөгчийн ялгаралд олон улс анхаарлаа хандуулж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхийн дулаарлыг цельсийн 1.5 хэмд тогтоох Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор улс орнууд хамтын гэрээ байгуулж тус бүр “Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр” /ҮТХН/-ийн зорилтыг боловсруулсан. Манай улсын хувьд ҮТХН-ийн 2030 оны зорилтын дагуу нүүрсхүчлийн хийг /CO₂/-г 22.7%-иар буюу 16.89 тонноор бууруулахаар уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох болон сааруулах үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү судалгаагаар Монгол Улсын хувьд уур амьсгалын эсрэг бодлого арга хэрэгслийн хувьд CO₂-г бууруулж байгаа эсэхийг КАЙЯ (Kaуа, 1997) загвараар хувьсагчдыг тодорхойлж нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлсон. Судалгааны үр дүнд SE болон P хувьсагчууд эерэг, хүчтэй хамааралтай ажиглагдсан. Иймд нүүрсхүчлийн хий ялгаруулалт нь эрчим хүчний хэрэглээгээр эдийн засагт дам нөлөө үзүүлж байна. Цаашид өөрийн улсын зорилтыг давуулан биелүүлж арга хэрэгслээ сайжруулснаар “CORBAN MARKET”-д орох боломжтой юм.

Түлхүүр үг: Уур амьсгалын өөрчлөлт, ҮТХН, нүүрстөрөгч ялгаруулалт, эрчим хүчний хэрэглээ, кайя загвар

1. Судалгааны үндэслэл

Дэлхийн уур амьсгал эрс өөрчлөгдсөөр ХХ-р зууны дунд үеэс хойш дэлхийн гадаргын дундаж температур ойролцоогоор 0.2 хэмээр нэмэгдэж байна. (Yongping Sun, Climate Risk Management, 2023) Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн олон олон зүйлд нөлөөлж байдаг байгалийн үзэгдэл бөгөөд уур амьсгалын эрсдэл нь ойрын арван жилд дэлхийн хамгийн чухал эрсдэл байсаар байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох ажлыг яаралтай хийх шаардлагатай байна. (Yongping Sun, The Global Risks Report , 2022) Хэрэв идэвхтэй арга хэмжээ авахгүй тохиолдолд 2050 онд дэлхийн ДНБ ойролцоогоор 4%-иар буурч, улмаар 7.9 их наяд ам.долларын эдийн засгийн алдагдалд хүрэх болно. (EIU, 2022) Уур амьсгал, байгалийн гамшиг нь 10 жилийн дунджаар үзэхэд дэлхийн хүн амын нийт нас баралтын 0.1 хувьд нь нөлөөлдөг (Hannah Ritchie, 2022). Мөн зөвхөн хүнтэй шууд хамааралтайгаар зогсохгүй нийгэм, эдийн засагт ч адил уур амьсгалын нөлөө үзүүлж байдаг. (Л.Даваажаргал, 2022) Уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн байдал нь хоорондоо харилцан хамааралтай ухагдахуун гэдгийг олон судалгаагаар баталсан боловч уур амьсгалын өөрчлөлтөөс үүссэн шоок, эдийн засагт үзүүлсэн нөлөөллийг харуулсан загвар одоогоор бий болоогүй байна. (Franziska Piontek, 2019) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохын тулд олон улсын эдийн засагт өөрчлөлт шинэчлэл хийх хэрэгцээ байгааг баталсаар байна. (CA&MN, 2022)

Хүн төрөлхтөн малтмал түлшинд харилцан хамааралтай болсноос хойш сүүлийн 200 жилийн хугацаанд агаар мандал дахь нүүрстөрөгчийн давхар ислийн агууламж 50%-иар нэмэгдсэн байна. Хүний буруутай үйл ажиллагаанаас болж үүсдэг метан хий нь ойролцоогоор дэлхийн дулаарлын 25% -ийг эзэлдэг. Метан хий нь нүүрс, хий, газрын тос олборлох, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулах үед ялгардаг. (UNDP, 2023)


Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд дэлхийн бүх улсууд ойрын хэдэн жилд хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах үйл ажиллагааг эхлүүлж, дэлхийн дулаарлыг цельсийн 1.5 хэмд хүргэхгүйн тулд тогтоон барих ёстой. Үүний тулд уур амьсгалын тогтолцоонд учруулах хүний аюултай үйл ажиллагааг зогсоох зорилгоор “Нэгдсэн үндэсний байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенци (НҮБ-УАӨСК)”-ыг 199 орны гишүүнчлэлтэйгээр 1992 онд байгуулж 1994 оноос хүчин төгөлдөр хэрэгжүүлж эхэлсэн. (UNDP, 2023)

Дээрх конвенцид суурилсан “Дэлхийн дулаарлын дундаж температурыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад цельсийн 2 хэмээс хэтрүүлэхгүй, улмаар цельсийн 1.5 хэмд хүргэлгүй тогтоон барих” гэсэн зорилго дэвшүүлсэн олон улсын гэрээг 2015 онд Парис хотод зохион байгуулагдсан COP21 -р баталж 2016 оноос хүчин төгөлдөр хэрэгжүүлж эхэлсэн. (UNDP, 2023)

Гарын үсэг зурсан дэлхийн улс орнууд Парисын хэлэлцээрт тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхийн тулд тус бүр “ Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)”-ийн зорилтийг боловсруулж уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх таван жил тутмын богино болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлагнах хэрэгтэй юм. (UNDP, 2023)

Монгол Улс 2016 онд УАӨ-ийн тухай НҮБ-ийн суурь конвенцийн Парисын хэлэлцээрт нэгдэн орсон. Тус хэлэлцээрт хүлээсэн үүргийн дагуу 2020 оноос ҮТХН-ийг шинэчлэн тогтоосон байна. Уг зорилтоор хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахаар өмнөх

зорилтоос ахиулан тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөөлөл, эрсдлийг бууруулах, түүнд дасан зохицох арга хэмжээг тодорхойлсон. (ҮТХН, 2019)




Зураг 1 МУ-ын CO2 ялгаруулалт, жилээр

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Монгол Улс “Тогтвортой хөгжлийн зорилт-13”-т тусгасан Парисын хэлэлцээрт хувь нэмрээ оруулах зорилгоор 2030 он гэхэд эдийн засаг, байгалийн нөөцийн менежментийн гол салбаруудад хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээнүүд, нөлөөллийг бууруулах хүчин чармайлтаа сайжруулж хүлэмжийн хийн ялгарлыг 22.7%-иар бууруулахаар МУ-ын засгийн газар 2019 оны 11 дүгээр сард 407 дугаар тушаалаар баталсан байна. (ҮТХН, 2019)

Монгол улс “Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр”-ийн зорилтдоо уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон сааруулах бодлогын зорилтыг гаргасан байна. Схем2 болон Схем3-т үзүүлээ.



Зураг 2 МУ-ын сааруулах бодлогын зорилт

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол



Зураг 3 МУ-ын дасан зохицох бодлого

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2. Судалгааны зорилго

Нүүрсхүчлийн хийн эдийн засагт үзүүлэх нөлөөлийг судлах.

3. Судлагдсан байдал

Дотоодод судлагдсан байдал:

1. Уур амьсгалын өөрчлөлтөөс Монгол улсын эдийн засагт үзүүлж болох сувгуудыг тодорхойлон панел бүтцийн VAR загвараар тооцоолол хийн температур 1*С-ээр нэмэгдэхэд ДНБ-ий өсөлт 0.48 хувиар саардаг бөгөөд энэ нөлөө нь 7-8 улирлын дараа мэдэгдэж улмаар нэг удаагийн шок нь 3 жилийн дараа тогтворждог. (Л.Даваажаргал, 2022)
2. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах нь санхүүгийн байгууллагуудыг хувьд ирээдүйд үүсэх сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх боломж бололцоо гэж харж болно. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх асуудлыг шийдвэрлэх хэдэн арга замаас дурдвал үр дүнг бууруулах эсвэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гэсэн сонголтийг үр дүнтэй гэж үзэж байна. (CA&MN, 2022)

Гадаадад судлагдсан байдал:

1. Англи улсын “Henley Business”-ын сургуулийн ICMA төвөөс “Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлт хүчин зүйлс ба хувьцааны өгөөж” гэх судалгааны бүтээлдээ хөрөнгийн зах зээлийн үнэ уур амьсгалын өөрчлөлт, түүнтэй холбоотой эрсдэлд дүн шинжилгээ хийж, макро болон микро түвшинд эмпирик нотолгоог танилцуулсан. Уг судалгаандаа уур амьсгалын фикик болон шилжилтийн биет эрсдлүүдийг авч үзсэн ба уур амьсгалын өөрчлөлтийг эрсдлийн нөлөөнд хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг онцлон тэмдэглэж хувьцааны өгөөжийн өндлөн огтлолын хэсэгт уур амьсгалын аль нөлөөг илүү нөлөөлж байгааг тодруулахын тулд дээрээс доош, доороос дээш хандлагын харьцуулан үзэж үүний үр дүнд зах зээл дээрх хөрөнгийн эдийн засагт шударгаар үнэлэлт өгөх нь ховор бөгөөд үүнийг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй гэж үзсэн байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийг байгууллагууд шударга бусаар үнэлсэнээс шалтгаалж дасан зохицох чадвар нь эрсдэлд орж болзошгүй байна. (ICMA Centre, 2022)
2. Yongping Sun, Ya Zou, Jingning Jiang, Ying Yang нарын “Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба цахилгаан эрчим хүчний салбарын санхүүгийн гүйцэтгэл” гэх судалгааны бүтээлдээ цахилгаан эрчим хүчний салбар нь эдийн засгийн үйл ажиллагааны үндэс суурь бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах гол оролцогч гэж тодорхойлсон байна. Иймээс уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд үндэсний эдийн засгийн тогтвортой үйл ажиллагаа эрчим хүчний салбарын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох, даван туулах чадварыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд БНХАУ-д бүртгэлтэй эрчим хүчний компаниуд дээр судалгаа хийн эмпирик үр дүнд үр дүн нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл болон бүртгэлтэй цахилгаан эрчим хүчний компаниудын санхүүгийн гүйцэтгэлийн хооронд мэдэгдэхүйц эерэг хамаарлыг харуулсан байна. Мөн санхүүгийн хөрөнгийн нөлөө үзүүлдэг зэрэг таамаглалаа баталж чадсан байна. (Yongping Sun, Climate Risk Management, 2023)
3. 2020 онд Африкийн улсуудын жишээн дээр хийгдсэн “ Африк дахь уур амьсгалын

өөрчлөлт ба санхүүгийн үндэс” гэх Ибаданы их сургуулийн гаргасан нийтлэлд дэлхийн дулаарлын олон нотолгоо нь хүмүүсийн сэтгэлийг түгшээж байгаа бөгөөд уур амьсгалаас үүдэн учирч буй хохиролд олон улс анхааралаа хандуулдаггүй бөгөөд олон улсын санхүүгийн зохицуулагчид уур амьсгалын өөрчлөлт нь санхүүгийн бодит эрсдэл дагуулдаг гэдгийг дурьдсан байна. Африкийн корпорациуудын үйлдвэрлэл, үйл явц нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт өртөмтгий байдал нь компаний ашигт ажиллагаа хөрөнгийн зах зээлд шууд дамжих мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн байна. (Oluseun Paseda, 2020)

4. 2023 онд хийгдсэн “Saudi Arabia’s Climate Change Policy and the Circular Carbon Economy Approach” судалгааны бүтээлд Саудын араб улсын хүлэмжийн хийн ялгаруулалт болон эрчим хүчний дахин боловсруулалтын нөлөөг авч судалсан. Тус улсын уур амьсгалын өөрчлөлтийн бодлогыг хэрхэн бууруулж байгааг тодорхойлж ямар бодлого аль жил илүү үр дүнтэй явагдаад байсныг “КАИҮА”-н загвараар тодорхойлсон. Үүнээс өөр ямар бодлого хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй болохыг харуулсан байна. (Thamir Al Shehri, 2023)

4. Судалгааны таамаглал

Судалгааны ажилдаа голчлон бодит CO₂-ын бууралт нь ҮТХН-т хүрэх эсэх магадлалыг урьдчилан таамаглаж МУ-ын хэрэгжүүлж буй бодлого арга хэрэгсэл нь нүүрсхүчлийн хий ялгаруулалт нь эдийн засагт нөлөө үзүүлдэг эсэхийг судалж авч үзнэ. Үүнд дараах таамаглалыг дэвшүүлж байна.

Таамаглал 1: Нүүрсхүчлийн хий ялгаруулалт нь эдийн засагт нөлөө үзүүлдэг.

Таамаглал 2: EG болон CE хувьсагчууд хоорондоо харилцан холбоо хамааралтай байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны ажилдаа голчлон CO₂-ын ялгаруулалт бодлогын хандлагыг тодорхойлсон бөгөөд 2000-2022 оны дата мэдээлэлд түшиглэн судлав. Ялгарлын хүчин зүйлсийн нөлөөллийг эдийн засгийн нийт түвшин үзэхийн тулд КАЙЯ загвар [1] ашигласан бөгөөд нэгжид ногдох эрчим хүчний ялгаруулалтыг IEA, CO₂ -ын ялгаруулалтыг Ourworldindata, хүн ам болон нэг хүнд ногдох ДНБ-г worldbank болон үндэсний статистикийн хорооноос тус тус цуглуулан авсан.

Кайя загвар нь уур амьсгалын өөрчлөлтийн арга хэрэгсэл, бодлого нь зөв сонгогдсон тохиолдолд үзүүлэлтүүд нь буурсан үзүүлэлттэй харагдана. Ерөнхийд нь Кайя нь улс орнуудын нүүрстөрөгчийн ялгаруулалт болон улс орнуудын хүчин чармайлтыг үнэлэхэд тохиромжтой.

Кайя загвар:

$$C = \frac{C}{E} \times \frac{E}{G} \times \frac{G}{P} \times P = CE \times EG \times GP \times P \quad [1]$$


Хүснэгт 1

Хувьсагчид	Тайлбар	Эх сурвалж
CE	Ашигласан эрчим хүчний нэгж тутамд гарч буй нүүрстөрөгчийн хэмжээ	Ourworldindata
P	Хүн амын тоо /нийт/	ҮСХ
GP	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн	ҮСХ
EG	Эдийн засгийн нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай эрчим хүчний нэгж	IEA

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Кайя загвараар (Кауа, 1997) 2000-2019 оны өөрчлөлтүүдийг CE, EG, GP, P хувьсагччуудын хоорондын хамаарлыг үнэлэв. Зураг 3 харна уу.



Зураг 3. Кайя загварын үзүүлэлтүүдийн харьцуулалт

Тайлбар: Дээрх графикт Кайягийн шинж чанарын элемент бүрийн утгуудын хамаарлыг харуулсан. Үүнээс харахад хүн ам өсөхөд мөн адил дотоодын нийт бүтээгдэхүүн өсч байна. эдийн засгийн нэгж бүтээгдэхүүн зйлдвэрлэхэд шаардлагатай эрчим хүчний нэгж /EG/ өсч буурах хандлага нь ашигласан эрчим хүчний нэгж тутамд гарч буй нүүрстөрөгчийн хэмжээ CE/ -гэй хамааралтай байна.

Хүснэгт 2. Correlations

		CE	EG	P	GP
CE	Pearson Correlation	1	.570*	.506*	-.545*
	Sig. (2-tailed)		.019	.023	.013
EG	Pearson Correlation		1	.546*	-.272
	Sig. (2-tailed)			.008	.245
P	Pearson Correlation			1	-.115
	Sig. (2-tailed)				.629
GP	Pearson Correlation				1
	Sig. (2-tailed)				

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тайлбар: Дээрх хүнсэгтэд судалгаанд ашигласан хувьсагч хоорондын хамаарлыг харуулав. Хамаарлын шинжилгээний үр дүнд CE болон P хувьсагч нь $R=0.506^{**}$ Sig 0.023 байгаа нь эерэг бөгөөд хүчтэй хамааралтай, CE болон GP нь $R=-0.545^{*}$ Sig 0.13 байгаа нь сөрөг бөгөөд сул хамааралтай байна. Энэ нь нэгж эрчим хүч үйлдвэрлэхэд гарч буй нүүрстөрөгчийн ялгарал хүн амын тооноос шалтгаалж нэмэгдэж улмаар хүний буруутай үйл ажиллагаас шалтгаалж CO₂-ын ялгаралт өсч болох юм. Иймд эрчим хүч ашиглалтын зөв хэрэглээг хүмүүс өдөр тутамдаа хэрэгжүүлбэл CO₂ ялгаралт ч мөн адил буурах хандлагатай.

ДҮГНЭЛТ

Уг судалгааны ажлын хүрээнд нүүрсхүчлийн хийн эдйн засагт үзүүлэх нөлөөллийг судалж авч үзсэн. Дараах дүгнэлтүүдийг тус тус гаргав.

1. Кайя загварын хувьсагчууд хооронд харилцан хамаарлаас харахад нүүрсхүчлийн хий болон эрчим хүчний хэрэглээ хоорондын өсөлт бууралт хамааралтай харагдаж байна.
2. Хүн амын өсөлт нь нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн буюу эдийн засгийн өсөлт харилцан хамааралтай өсөлт байна.
3. Хүн амын өсөлтөөс шалтгаалж эрчим хүчний хэрэглээ өсч байгаа нь аж үйлдвэрлэл өсөлттэй хамааралтай.

Дээрх дүгнэлтүүдийг нэгтгэвэл хүн амын өсөлт нэмэгдэхийн хэрээр үйлдвэрлэл үйлчилгээ өсч улмаар эрчим хүчний хэрэглээ өндөр түвшинд хүрснээр нүүрсхүчлийн хий ялгаруулалт эрчимжиж байна. Мөн эдийн засаг болон нүүрсхүчлийн хийн урвуу хамаарал нь эрчим хүчний хэрэглээг хэмнэлт үүсгэж чадвал эдийн засгийн өсөлтийг авчрах боломж байгааг харуулж байна.

Мөн дээрх дүгнэлтэд үндэслэн цаашид хийх ажлын санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн арга хэрэгслийг дахин сайжруулах боломжийг бусад орныхтой харьцуулан судлах.
2. ҮТХН-ийг давуулан биелүүлж “CORBAN MARKET”-д орох боломжийг судалж, улмаар эдийн засагт үзүүлэх өгөөжийг судлах.

Хязгаарлах нөхцөл:

1. Тус судалгааны ажил нь КАЙЯ загварт үндэслэсэн болно.
2. Зөвхөн 2000-2019 оны мэдээлэлд үндэслэсэн болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- CA&MN, R. (2022). *Уур амьсгалын өөрчлөлт*. Получено из RSPB: <https://s3.rspb-mn.org/library/msme-finance/ksep-lib-climate-risk.html>
- EIU, S. G. (2022). *Weather Warning: Assessing Countries' Vulnerability To Economic Losses From Physical Climate Risks*. Получено из Resilience to climate change? A new index shows why developing countries will be most affected by 2050: <https://www.eiu.com/n/campaigns/resilience-to-climate-change/>, <https://www.spglobal.com/ratings/en/research/pdf-articles/220427-economic-research-weather-warning-assessing-countries-vulnerability-to-economic-losses-from-physical-clim-101529900>.
- Franziska Piontek, E. K. (2019). *Environmental & Resource Economics*. Получено из Environmental & Resource Economics: https://econpapers.repec.org/article/kapenreec/v_3a73_3ay_3a2019_3ai_3a4_3ad_3a10.1007_5fs10640-018-00306-7.htm
- Hannah Ritchie, P. R. (2022). *Natural Disasters*. Получено из Ourworldindata: <https://ourworldindata.org/natural-disasters>
- ICMA Centre, H. B. (2022). *Climate change, risk factors and stock returns*. Получено из International Review of Financial Analysis: [file:///C:/Users/Dell/Downloads/1-s2.0-S1057521921002568-main%20\(2\).pdf](file:///C:/Users/Dell/Downloads/1-s2.0-S1057521921002568-main%20(2).pdf)
- Каа. (1997).
- Oluseun Paseda, J. O. (31 08 2020 г.). *Climate Change and Finance in Africa*. Получено из Research Journal of Finance and Accounting : https://www.researchgate.net/publication/344115777_Climate_Change_and_Finance_in_Africa_Some_Theoretical_and_Practical_Justifications
- Thamir Al Shehri, J. F. (2023). Получено из <file:///C:/Users/Dell/Desktop/Climate%20change's%20papers/Saudi%20Arabia%20s%20Climate%20Change%20Policy%20and%20the%20Circular%20Carbon%20Economy%20Approach.pdf>
- UNDP. (2023). Получено из <https://www.undp.org/mn/mongolia/news/uur-amsgalyn-oorchloltiyn-tol-bichig-uur-amsgalyn-oorchloltiyn-asuudlaarkh-odor-tutmyn-garyn-avлага>
- Yongping Sun, Y. Z. (2022). *The Global Risks Report* . Получено из Climate Change : <https://www.ipcc.ch/report/ar6/wg2/about/how-to-cite-this-report/>, <https://cn.weforum.org/reports/global-risks-report-2022>.
- Yongping Sun, Y. Z. (2023). *Climate Risk Management*. Получено из Climate Risk Management: https://www.sciencedirect.com/science/article/pii/S221209632200081X?ref=pdf_download&fr=RR-2&rr=81b2b8295a21a9bb#b0125
- Л.Даваажаргал, Б. Э. (2022). *Монгол банк*. Получено из https://www.mongolbank.mn/file/789b7e2a3a9ab3cacc372138a0727958/files/17_7.pdf: https://www.mongolbank.mn/file/789b7e2a3a9ab3cacc372138a0727958/files/17_7.pdf
- ҮТХН. (2019). *ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТОДОРХОЙЛСОН ХУВЬ НЭМРИЙН ЗОРИЛТ*. Получено из <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210340&showType=1>

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ НЬ

(Мандах Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистрын
хөтөлбөрийн жишээн дээр)

Ч.Төрбадрах^{1a} , Ө.Мөнхзаяа^{2b}

¹Мандах ИС, Сургалт эрхэлсэн проректор, Доктор (Ph.D), профессор

²Мандах ИС, Бизнесийн удирдлагын магистрант

^aturbadrakh.ch@mandakh.edu.mn

^bmunkhzaya.u@mandakh.edu.mn

ХУРААНГУЙ

Сургалтын хөтөлбөр гэдэг нь тодорхой түвшний боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловсролын зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хичээлийн агуулга, сурах, сургах аргазүй, үнэлгээний аргазүй, орчин, хэрэглэгдэхүүн, тэдгээрийн хоорондын нарийн уялдаа холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичиг юм. Орчин үеийн дээд боловсролын чиг хандлагын дагуу үр дүнд суурилсан дээд боловсролын сургалтын хичээлийн суралцахуйн үр дүн (CLO-Course Learning Outcome) болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийн (PLO-Program learning outcome) хамаарлыг агуулгын хувьд нарийвчлан авч үзэн судлахыг зорьсон. Хичээлийн суралцахуйн үр дүн (CLO) болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн (PLO) хоорондын хамаарлыг судалснаараа тухайн хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийн үзүүлэлтийг үндэслэн харьцуулан дүгнэх боломжтой юм. Мөн үнэлгээний үр дүнд үндэслэн багш тухайн суралцахуйн үр дүнг оюутанд хамгийн сайн эзэмшүүлэхийн тулд сургалтын шинэлэг заах аргууд, хүргэх хэлбэрүүдээс тохиромжтойг сонгон хичээлийн бүлэг сэдэв бүрд ямар суралцахуйн үр дүнгүүд хамаарах, үүнээс үүдэн сургалтын аргазүй, хүргэх хэлбэрүүдийг хэрхэн ашиглахаа төлөвлөсөн байдал зэрэг нь хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийн гол үзүүлэлт болно. Ингэснээр хичээлийн суралцахуйн үр дүнгээс хөтөлбөрийн суралцахуйн үр дүн шууд хамаарна.

Түлхүүр үг: Дээд боловсрол, Хичээлийн суралцахуйн үр дүн (CLO), Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO), сургалтын хөтөлбөр

ОРШИЛ

Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоо нь суралцахуйн үр дүнгүүд, сургах, суралцах үйл ажиллагаа, сургалтын үнэлгээний гэсэн 3 үндсэн хэсгээс тогтоно. Суралцахуйн үр дүнгийн хэсэгт сургууль, хөтөлбөр, хичээлийн түвшинд суралцахуйн төсөөлсөн үр дүнг урьдчилан тодорхойлох бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талууд буюу ажил олгогчид, мэргэжлийн байгууллагууд, багшлах бүрэлдэхүүн, төгсөгчид, оюутнуудаас санал асуулга авах замаар сургалтын төсөөлсөн үр дүн буюу оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагуудыг тэдний хэрэгцээ шаардлагатай уялдуулдаг. Суралцахуйн үр дүнгийн хамгийн доод нэгж нь хичээлийн суралцахуйн үр дүн (CLO) бөгөөд тухайн хичээлийн суралцахуйн үр дүнг оюутан маш сайн эзэмшсэнээр хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, цаашлаад боловсролын зорилго, зорилт хангагдах ёстой. Энэ үүднээс хичээлийн болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарлыг тус хөтөлбөрийн хүрээнд судлахыг зорив.

Судалгааны үндэслэл

Дээд боловсролын салбарт 32 жил үйл ажиллагаа явуулж байгаа МАНДАХ ИХ СУРГУУЛЬ нь дээд боловсролын тухай хууль, боловсролын тухай хууль, багшийн хөгжлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газар Алсын хараа 2050, БМИҮЗ-ийн дүрэм журамд нийцсэн сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулсаар байна. Бид бүх түвшний сургалтын үйл ажиллагааныхаа чанарт голлон анхаарч ажилладаг. Ингэхдээ дотоодын, гадаадын хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар тасралтгүй үнэлүүлж илсэн. 2024 оны байдлаар манай сургуульд хэрэгжиж буй бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн оюутанд хэрхэн хүрч байгаа цаашлаад хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчдоос тавьж буй шалгуур шаардлагад бүрэн нийцүүлэх зорилгоор хөтөлбөр төлөвлөлтийн байдал буюу хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг хичээлийн суралцахуйн үр дүнтэй хэрхэн уялдуулж байгааг бодитоор үнэлэх шаардлагатай гэж үзсэн.

Судалгааны зорилго

Мандах Их Сургуулийн “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрийн төлөвлөлтийн байдал буюу хичээлийн болон суралцахуйн үр дүнгийн хамаарлыг судалж бодит нөхцөл байдалд үндэслэн санал зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилт

- Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн талаарх онолын ойлголтуудыг судлах
- Мандах Их Сургуулийн “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрийн төлөвлөлтийг үнэлэх
- Мандах Их Сургуулийн “Бизнесийн удирдлага”-ын хөтөлбөрийн өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн сайжруулах санал зөвлөмж гаргах

Судлагдсан байдал

Дээд боловсролын сургалтын асуудал нь олон улсын хүрээнд яригддаг өргөн хүрээтэй асуудал тул тус сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаа жил ирэх тусам улам баяжиж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаа нэлээдгүй байна. Сэдвийн судлагдсан байдлыг ерөнхийд нь харвал сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаанд оролцогч талуудын буюу судалгааны субъект нь багш болон оюутан байна. Харин сургалтын хөтөлбөр, бичиг баримт талаасаа харьцангуй бага судлагдсан бөгөөд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ч манай улсын хувьд дутагдалтай байна.

Сэдвийнхээ хүрээнд магистрын зэрэг горилсон бүтээлүүд болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцсон өгүүллүүд бусад холбогдох байгууллагуудаас гаргасан тохимолуудтай танилцлаа. Дээрх судалгаанууд нь дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн зөвхөн тодорхой хэсгүүд дээр хийгдсэн судалгаанууд бөгөөд энэхүү судалгаа маань хамрах хүрээ болон судалгааны арга зүйн хувьд ялгаатай. Учир нь энэхүү судалгаа нь баримт мэдээлэл судлах аргаар мэдээлэл цуглуулан тусгай загвараар мэдээллийг нэгтгэсэн бөгөөд хөтөлбөр төлөвлөлтийг үнэлэхдээ хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийг нэг бүрчлэн уялдуулж нэгтгэн шинжилгээг хийсэн болно.

Судалгааны арга зүй

Судалгааг 2022 онд батлагдсан “Бизнесийн удирдлага”-ын магистрын сургалтын төлөвлөлтийг тодорхойлохдоо тус хөтөлбөрийн нэгж хичээл тус бүрд тодорхойлсон суралцахуйн үр дүн (CLO), хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO)-гийн уялдааг EXCEL-PIVOT программаар нэгтгэн дүн шинжилгээ хийсэн.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Магистрын хөтөлбөрийн төлөвлөлтийн байдал

Мандах их сургууль нь хөгжлийнхөө стратегийг 5 жилээр төлөвлөн хэрэгжүүлж ирсэн ба 2017-2022 он хүртэлх стратеги төлөвлөгөөндөө дээд сургуулиас их сургуулийн ангилалд багтах нөхцөл, шаардлагыг хангах зорилт дэвшүүлэн амжилттай хэрэгжүүлсэн байна. Энэ хүрээнд 2018 оноос “Бизнесийн удирдлага”-ын магистрын болон докторын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

Ийнхүү “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрийн зорилго, зорилт (PEO)-ыг тус сургуулийн эрхэм зорилго, алсын хараатай уялдуулан дараах байдлаар тодорхойлсон байна.

Тус хөтөлбөрийн зорилго нь салбарын хөгжлийн чиг хандалга, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн оновчтой бизнесийн шийдвэр гаргахад шаардлагатай, онолын болон судалгаа шинжилгээний орчин үеийн арга зүйн мэдлэг, чадвар, хандлагатай, олон улсад

хүлээн зөвшөөрөгдөхүйц бизнесийн удирдлагын мэргэжилтэн, судлаачийг бэлтгэхэд оршино.

Энэхүү зорилго нь Ахисан түвшний сургуулийн зорилго болоод Мандах их сургуулийн зорилготой нийцсэн байдлаар тодорхойлогдсон бөгөөд тус зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах **зорилтуудыг (PEO)** дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үүнд:

1. Бизнесийн салбарын хөгжлийн чиг хандлага, үндэсний болон олон улсын стандарт шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрөөр чанартай сургалт явуулна.
2. Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай судлаачийг бэлтгэнэ.
3. Орчин үеийн бизнесийн салбарын удирдлагын шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэгийн менежмент, хүний нөөцийн менежмент, төслийн менежмент, эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг мэргэжлийн ахисан түвшний мэдлэг, чадвартай судлаач, мэргэжилтэн бэлтгэнэ.
4. Суралцагчдад ахисан түвшний судалгаа, шинжилгээний ажлыг хийх, орчин үеийн судалгааны арга зүйг эзэмшүүлнэ.

Цаашлаад “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO) буюу мэдлэг, чадвар хандлагыг хөтөлбөрийн боловсролын зорилт (PEO)-той уялдуулан дараах байдлаар тодорхойлсон байна. (Хүснэгт 1.1)

Хүснэгт 1.1 Хөтөлбөрийн боловсролын зорилтууд (PEO) ба суралцахуйн үр дүнгийн (PLO) хамаарал

№	Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт	Хөтөлбөрийн сургалтын зорилгууд			
		1	2	3	4
PLO1.1	Эрдэм шинжилгээ, судалгааны онол, арга зүйн мэдлэг эзэмшүүлэх				
PLO1.2	Нийгэм, эдийн засаг болон мэдээллийн технологийн мэргэжлийн мэдлэг				
PLO1.3	Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйн тухай мэдлэг				
PLO1.4	Бизнесийн удирдлагын мэргэжлийн онолын болон практик хэрэглээний мэдлэг				
PLO2.1	Багаар ажиллах ур чадвар, манлайлах, удирдах				
PLO2.2	Харилцааны болон гадаад хэлээр харилцах, ашиглах				
PLO2.3	Тоон өгөгдөл цуглуулах, боловсруулах, шинжлэх, дүгнэх				
PLO2.4	Аливаа асуудлыг системтэй төлөвлөх, харьцуулах, тунгаан боловсруулах				
PLO3.1	Бизнесийн үйл ажиллагаа төлөвлөх, удирдах, хянах, хэрэгжүүлэх				
PLO3.2	Байгууллагын хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх				
PLO3.3	Мэдлэг болон бүтээмжийн менежмент, зах зээлийн судалгааг хийх				
PLO3.4	Салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг судлах, шинжилгээ хийх, шийдвэр гаргах				

Мөн тус хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний багц цагийн хуваарилалтыг харвал “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөр нь 30 багц цагаас доошгүй байгаа ба Мэргэжлийн суурь хичээл нийт 10 багц цаг, үүний 5 судалгааны арга зүйн хичээл, үлдсэн нь онолын үндсэн хичээл байна. Харин мэргэшүүлэх хичээл 20 багц цагаас доошгүй байгаа ба үүний 16 багц цаг нь заавал судлах, үлдсэн нь сонгон судлах хичээл байна. (Хүснэгт 1.2)


Хүснэгт 1.2 Сургалтын төлөвлөгөөний кредитийн хуваарилалт

Хичээлийн төрөл	Заавал судлах хичээлийн		Сонгон судлах хичээлийн		Нийт судлах хичээлийн	
	кредит	хувь	кредит	Хувь	кредит	Хувь
А. Мэргэжлийн суурь хичээл	10	33.3%			10	33.3%
Б. Мэргэшүүлэх хичээл	16	53.3-51.6%	4-5	13.3-16.1%	20-21	66.7%
Нийт дүн	26	86.7-83.9%	4-5	13.3-16.1%	30-31	100%

Ийнхүү сургалтын төлөвлөгөөн дэх нэгж хичээлээр олгогдох суралцахуйн үр дүн (CLO) буюу мэдлэг, чадвар, хандлага тус бүрийг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO)-тэй уялдуулж харвал тус магистрын хөтөлбөрийн хүрээнд нийт хичээлүүдийн хувьд давхардсан тоогоор 446 мэдлэг, чадвар, хандлага (CLO)-оор дамжуулан хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO)-г оюутанд олгохоор байгаа бөгөөд хөтөлбөрийг 30-31 багц судлахаар буюу сонгон судлах хичээлийн хувьд 4-5 багц цагийн 2-3 хичээл судалдаг гэж тооцвол ойролцоогоор 330 орчим CLO-г эзэмшиж төгсөхөөр байна. Тэгвэл үүний 26 хувь

нь мэргэжлийн суурь хичээлээр, 59 хувь нь мэргэжлийн заавал судлах хичээлээр, үлдсэн хувь нь мэргэжлийн сонгон судлах хичээлээр олгогдоно гэж хэлж болохоор байна.

Доорх зургаас харахад хөтөлбөрийн хүрээнд PLO 1.4 буюу бизнесийн удирдлагын мэргэжлийн онолын болон практик хэрэглээний мэдлэг болон PLO 2.3, 2.4 буюу тоон өгөгдөл цуглуулах, боловсруулах, шинжлэх, дүгнэх, аливаа асуудлыг системтэй төлөвлөх, харьцуулах, тунгаан боловсруулах чадварыг хамгийн их CLO-гоор олгодог бол тухайн салбарт ажиллахад шаардлагатай мэргэжлийн ур чадваруудын хувьд PLO 3.1 буюу бизнесийн үйл ажиллагаа төлөвлөх, удирдах, хянах, хэрэгжүүлэх чадварыг түлхүү олгодог байна. (Зураг 1.1)



*Зураг 1.1 Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг олгох байдал
(Эх сурвалж: Хөтөлбөрийг 30-31 багц цагаар тооцож гаргасан судлаачийн тооцоолол)*

“Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрөөр олгож буй нэгж хичээлүүдийн суралцахуйн хүрэх үр дүн (CLO) хөтөлбөрийн агуулгын түвшинд ямар давтамжтай олгогдож байгааг тоон үр дүнгээр харуулбал мэргэжлийн суурь хичээлээр 88 CLO, мэргэжлийн сонгон судлах хичээлээр ойролцоогоор 50 орчим CLO олгож байгаа бол мэргэжлийн заавал судлах хичээлээр 197 CLO буюу хамгийн их CLO олгогдож байна. (Хүснэгт 1.3)

Хүснэгт 1.3 Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн	Мэргэжлийн суурь	Мэргэжлийн заавал судлах	Мэргэжлийн сонгон судлах	Нийт
PLO1.1 Эрдэм шинжилгээ, судалгааны онол, арга зүйн мэдлэг эзэмшүүлэх	17	17	9	43
PLO1.2 Нийгэм, эдийн засаг болон мэдээллийн технологийн мэргэжлийн мэдлэг	11	33	7	51
PLO1.3 Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйн тухай мэдлэг	8	18	10	36
PLO1.4 Бизнесийн удирдлагын мэргэжлийн онолын болон практик хэрэглээний мэдлэг	7	43	11	61
PLO2.1 Багаар ажиллах ур чадвар, манлайлах, удирдах	8	4		12
PLO2.2 Харилцааны болон гадаад хэлээр харилцах, ашиглах	8	6	8	22
PLO2.3 Тоон өгөгдөл цуглуулах, боловсруулах, шинжлэх, дүгнэх	14	15	4	33
PLO2.4 Аливаа асуудлыг системтэй төлөвлөх, харьцуулах, тунгаан боловсруулах	7	15	11	33
PLO3.1 Бизнесийн үйл ажиллагаа төлөвлөх, удирдах, хянах, хэрэгжүүлэх	2	21	6	29
PLO3.2 Байгууллагын хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх		4	3	7
PLO3.3 Мэдлэг болон бүтээмжийн менежмент, зах зээлийн судалгааг хийх		8	4	12
PLO3.4 Салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг судлах, шинжилгээ хийх, шийдвэр гаргах	6	13	4	23
Нийт	88	197	50*	335

**Хөтөлбөрийг 30-31 багц цагаар тооцож гаргасан судлаачийн тооцоолол*

Мөн магистрын хөтөлбөрийн хувьд 1.5-2 жил суралцдаг бөгөөд тухайн хугацааны сургалт нь 3 улиралд хуваагдана. Сургалтын төлөвлөлөгөөнд тусгагдсан нийт хичээлүүдийн хувьд суралцах улирал нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй нийцсэн эсэхийг тодруулахад I улирал буюу намрын улиралд шинээр элсэгч магистрантууд нь мэргэжлийн суурь хичээлүүдээ үздэг бөгөөд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг нэгж хичээлийн 88 CLO-оор эзэмшинэ. Мөн тухайн улиралд ихэвчлэн судалгааны арга зүй болоод тоон өгөгдөл цуглуулах мэдээллийг боловсруулж шинжлэн дүгнэх арга зүйд суралцдаг байна. Энэ нь ахисан түвшний болоод Мандах ИС-ийн эрхэм зорилгод тусгагдсан судлаач мэргэжилтэн бэлтгэх үндэс суурийг тавьж байна гэж үзэж болохоор байна.

Харин II улирал буюу хаврын улиралд мэргэжлийн заавал судлах хичээлүүдийг үзэж эхлэх бөгөөд тухайн улиралд хамгийн багадаа нэгж хичээлийн 223 CLO-г эзэмшинэ. Нарийвчлан авч үзвэл тус улиралд бизнесийн удирдлагын мэргэжлийн онолын болон практик хэрэглээний мэдлэг түлхүү эзэмшдэг байна.

Харин III улирлын хувьд оюутны эзэмших CLO нь мэргэжлийн болон судалгааны магиструудын хувьд ялгаатай бөгөөд аль чиглэлээр суралцахаас хамаардаг байна. Өөрөөр хэлбэл судалгааны магистрантуудын хувьд судалгааны ажилдаа анхаарлаа

хандуулах бол мэргэжлийн магистрантуудын хувьд сонгон судлах буюу багц цагаа гүйцээх 2-3 хичээлийг үздэг ба тухайн хичээлүүдээр PLO олгогдоно.

Дээрх судалгааг нэгтгэн авч үзвэл хөтөлбөрөөр олгогдох суралцахуйн үр дүнгүүд (PLO) буюу мэргэжлийн онол болон практик хэрэглээний мэдлэг, судалгаа шинжилгээний онол, арга зүйн талаарх мэдлэг болон хөтөлбөрөөр олгогдох чадварууд, мэргэшүүлэх хичээлээр эзэмших мэргэжлийн мэдлэг, ур чадваруудын хувьд зохих түвшинд эзэмшүүлж байгаа нь тус сургуулийн “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрийн хувьд сургалтын агуулга нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй нийцтэй байна гэж үзэж болохоор байна.

ДҮГНЭЛТ

Тус сургуулийн “Бизнесийн удирдлага”-ын магистрын хөтөлбөрийн хувьд сургалтын агуулга нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг ерөнхийд нь хангаж байна гэж үзэж болохоор байна. Гэвч “Бизнесийн удирдлага” хөтөлбөрийг магистрын түвшинд хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO)-г хичээлийн суралцахуйн үр дүн (CLO)-гийн уялдаа холбоог нэгтгэх явцад тус хөтөлбөрийн нэгж хичээл тус бүрийн суралцахуйн үр

дүнгүүдэд дараах асуудлууд байсан бөгөөд хөтөлбөр сайжруулалт хийхдээ анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Хичээлийн суралцахуйн үр дүн (CLO) буюу тухайн хичээлээр эзэмших мэдлэг, чадвар хандлагын тоо харьцангуй олон байсан бөгөөд 3 багц багийн хичээлийн хувьд хамгийн ихдээ нийт 26 мэдлэг, чадвар, хандлагатай байсан бол хамгийн багадаа 11 CLO-той байна. Харин 2 багц цаг хичээлийн хувьд 24 CLO-той байгаа нь хичээлийн багц цагаас үл хамаарч байгааг харуулж байна.
- Мөн нэгж хичээлийн CLO-г тодорхойлохдоо “Хичээлийн стандарт”-д тавигдах шаардлагын дагуу тухайн хичээлийн үр дүн (CLO) нь өөр хичээлийн үр дүн (CLO)-тэй давхцалгүй байх гэсэн шаардлагыг хангах хэрэгтэй.
- Хичээлийн суралцахуйн үр дүнг (CLO) тодорхойлсон байдлыг харвал найруулгын хувьд хичээлийн сэдвийг шууд тавих, олон үйл үгээр тодорхойлох, хэмжигдэхгүй, идэвхгүй үйл үг ашигласан зэрэг асуудлууд байна.
- Хичээлийн суралцахуйн үр дүн (CLO) болон сургалтын арга зүй, хэлбэрийн хамаарлыг хөтөлбөрт тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.
- Тус хөтөлбөрийн хувьд сургалтын төлөвлөгөөнд байгаа нэгж хичээлүүд нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй (PLO) уялдсан байдлыг хэдийгээр тодорхойлж өгсөн боловч хэрхэн хамааралтай байгааг нарийн тодорхойлоогүй байна.
- Цаашлаад хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO)-г сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, ажил олгогчийн шаардлага, улс орны бодлого болоод олон улсын чиг хандлага зэрэг түүнд хамаарах олон хүчин зүйлд нийцүүлэн **оновчтой, товч** тодорхойлж өгөх хэрэгтэй бөгөөд тус хөтөлбөрийн PLO-г найруулгын хувьд засан сайжруулах шаардлагатай нь харагдлаа.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дээрх үр дүнд үндэслэн хөтөлбөр сайжруулалтыг хийхдээ дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Магистрын түвшний сургалтад тухайн хөтөлбөрийн нэгж хичээлийн суралцахуйн үр дүнг боловсруулахдаа хичээлийн хэлбэрийг харгалзах
2. CLO-ийн давхардал байгаа эсэхийг тодруулж, давхардал байгаа бол арилгах
3. Олон үйл үг оруулсан суралцахуйн үр дүнг (CLO) дараа нь үнэлэхэд бэрхшээлтэй болдог бөгөөд аль ур чадварыг хөгжүүлснийг шалгахад ойлгомжгүй болдог учир олон үйл үгийг ашиглахгүй байх
4. Мөн хичээлийн суралцахуйн үр дүнг боловсруулахдаа тодорхойгүй, хэмжигдэхгүй, идэвхгүй үйл үгнүүдийг ашиглахгүй байх хэрэгтэй ба мэдлэг, чадвар, хандлагын хувьд идэвхтэй үйл үгийг оруулан боловсруулах
5. Хичээлийн суралцахуйн үр дүн (CLO)-г сургалтын арга зүй, хэлбэрийн хамаарлыг хөтөлбөрт тусгаж өгснөөр тухайн нэгж хичээлийн CLO-г оюутнуудад ямар арга зүйгээр хүргэж байгааг тодорхой болгож өгөх юм.
6. Олон улсын судалгаанаас үзэхэд бусад улсад PLO-г олон төрлийн аргаар үнэлдэг ч манай хөтөлбөрүүдийн хувьд үнэлгээний тогтсон арга байхгүй байгааг анхаарах
7. Мөн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад баримтлах зарчимд үндэслэн суралцахуйн үр дүн (PLO)-г товч бөгөөд тодорхой хэмжиж болохуйцаар тодорхойлох саналтай байна

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Орхон, Г. (n.d). Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн тухай ойлголтыг тодруулах нь.
2. Egan, K. (2003). *What is Curriculum?* In *Journal of the Canadian Association for Curriculum Studies* (Vol. 1, Issue 1).
3. Fraser, S. P., & Bosanquet, A. M. (2006). *The curriculum? That's just a unit outline, isn't it?* *Studies in Higher Education*, 31(3), 269–284.
4. Ismail, I., & Othman, R. (2023). *Programme Learning Outcomes (PLO) as a measure for academic success in postgraduate studies: A case study of a Malaysian Higher Learning Institution.* *Training, Language and Culture*, 7(1), 21–39. <https://doi.org/10.22363/2521-442X-2023-7-1-21-39>
5. *Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж.* (2018).
6. Shaheen, M. (2023). *Decision tree for PLOs of undergraduate computing program based on CLO of computer programming.* *Interactive Learning Environments*, 31(4), 2452–2470.
7. МУБИС. (2021). *Монгол улсын их, дээд сургуулиудад хэрэгжүүлж буй бакалаврын боловсролын сургалтын хөтөлбөр судлалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал.*
8. *Чанарын дотоод баталгаажуулалт.* (2019).

THE CORRELATION BETWEEN PSYCHOLOGICAL (MOTIVATION, ATTITUDE, PERCEPTION, AND MEMORY) PROCESS AND PURCHASING INTENTION OF THE DEPOSITORS

^{1a}Sainjargal Bayarsaikhan, ^{2b}Burmaa Otgonbayar, ^{3c}Tserennyam Sukhbaatar

¹Ph.D, of Mandakh University, Mongolia

² Assoc. Prof. (Ph.D), of Mandakh University, Mongolia

³Brigham Young University – Hawaii, Laie, USA

sainjargal@mandakh.edu.mn , burmaa.o@mandakh.edu.mn ^c tseegy@byuh.edu

ABSTRACT

The psychological process (motivation, attitude, cognition, and memory) is the primary stimulus for decision-making. The optimal marketing policy can be determined if these psychological factors are identified correctly. Therefore, this research is dedicated to identifying factors such as demography, status, and psychology for choosing savings services from commercial banks in Mongolia. A total of 1,801 people were involved in the research with random sampling, and psychological differences between those who have savings and those who do not were studied.

Keywords: Consumer behavior, motive, attitude, perception, memory, learning, personality, purchasing decision, mongolian banking service

INTRODUCTION

Since the world-shaking pandemic which strike with fear, the lifestyle concept of the customers has been changed. This event strongly influenced in their attitude to increase their savings to present from risks to protect themselves. One example of this is, Europeans typically save up 12 percent of their income, the amount of this savings has been increased to 19 percent in 2020 and 2021 as family members stayed home and furlough scheme has supported the income²². Another example of this event is our country and amount of currency savings has reached MNT 4.6 trillion and it increased by MNT 59.0 (1.3%) from the previous month and by MNT 452.5 (10.9%) same period of last year². Therefore, when works of the researchers is compared with the purpose of determining how the psychological factors of the customers influence in decision making of savings purchase, it was mentioned that psychological indexes influence strongly in the financial product selection. Method to segment the market based on this influence factor is spread. For instance, the researches on segmenting financial service market based on the correlation of demography parameters and

²² <https://www.imf.org/en/Blogs/Articles/2022/02/10/europes-consumers-are-sitting-on-1-trillion-euros-in-pandemic-savings>

psychological factors. (Alfansi & Sargeant, 2000; Ansell, Harrison, & Archibald, 2007; Keller & Siegrist, 2006), (Makgosa, Matenge, & Mburu, 2016).

Besides, banking and financial organizations strive for effective market of their products and services to their customers in micro markets, for this purpose they need to have a better understanding of their customers' behavioral and psychographic characteristics. (Ou et al., 2017; Mogaji et al., 2018; Monferrer et al., 2019), (Calvo-Porrall & Levy-Mangin, 2020). It has been considered demographic and psychographic parameters are the data that best categorize consumers of banking and financial services that meet these requirements. (Ansell et al., 2007; Funfgeld & Wang, 2009; Keller & Siegrist, 2006), (Makgosa, Matenge, & Mburu, 2016). Therefore, in this study, we aimed to investigate how consumer psychological factors influence decision-making when choosing a commercial bank savings service.

Literature Review

Economists and social scientists define savings as the portion of income that remains after consumption has been deducted (Lunt & Livingstone, 1991), while researcher Katona (1975) states that ordinary people do not consider it as savings, but accumulation, the money deposited in bank accounts or other assets to protect against future uncertainty or to purchase goods and services. Lunt & Livingstone, 1991) (Fisher & Anong, 2012).

As the researchers mentioned that the consumer's psychological factors have a certain influence on the decision to purchase any product or service, the relationship between these factors and the purchase decision which is described in detail in the theory of consumer behavior is briefly specified below.

Numerous researches have been done on how individual behavior is linked to motivations, impulse, and habits, and how these influence purchasing decisions. Therefore, more attempts have been made to segment the market based on differences in individual behavior. This is because researchers believe that individual behavior has an important impact on purchasing. Behavior is defined as a consistent quality of a person's personal behavior. While some researchers have argued that behavior is a real personality trait, others have criticized it as an opinion created by psychologists (Villani & Wind, 1975).

Sigmund Freud's (1910) psychoanalytic theory is considered an invaluable contribution to marketing research. Researchers have been interested in the study of how the individual's "unconscious behavior" affects the purchase decision. This theory relates individual behavior to "libido," and explains that the psychological forces of "ego", "superego", and "id" govern behavior and decision-making. Therefore, the "Psychoanalytical model" of consumer purchase decision-making has been developed. This model explains that three levels of consciousness (id, ego, and superego) work to influence a person's behavior and purchasing decisions, and it can be understood that the implicit symbols of a company's name and logo influence a person's consciousness to make them buy that product instead of buying similar products from another company (Jisana.T.K, 2014).

